



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2016.09.15, ПҮРЭВ ~ №198 (476)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн

Куба улсад хийж буй албан ёсны айлчлал эхэллээ.

Засгийн газар 11 агентлагийн даргын сонгон шалгаруулалтын захиалга хүргүүлжээ.

Ардчилсан намын Үндэсний зөвлөлдөх хороо маргааш хуралдана.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаар дипломат уулзалт болов.

Байнгын хорооны гишүүд Төв цэвэрлэх байгууламжийн ажилтай танилцлаа.

ЭДИЙН ЗАСАГ

20 гаруй компани Японд бүтээгдэхүүн экспортолохоор гарал үүслийн гэрчилгээ авчээ.

Монгол Улсын гадаад худалдааны бараа эргэлт 5.1 тэрбум ам.доллартай тэнцэв.

БНЧУ руу энэ оны эхний хагас жилд 140 сая ам.долларын бүтээгдэхүүн экспортолжээ.

Энэ сард улсын хэмжээнд 380,600 тонн өвс, 2700 тонн гар тэжээл бэлтгээд байна.

НИЙГЭМ

Төрөлхийн тэмбүүтэй хүүхэд нэмэгдэж буйд эмч нарын сэтгэл зовниж байна.

АТГ эрүүгийн 47 хэрэгт мөрдөн байцаалт явуулж, дөрвөн хэргийг прокурорт шилжүүлэв.

Профессор Д.Баярсайхан ил хаадын судлалын талаар хоёр ном эмхтгэн хэвлүүлжээ.

Мал зүйч нар хонинд үр хөврөл шилжүүлэн суулгах технологийг судалсан байна.

Монгол төрийн мэргэн сайд А.Амарын мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэнэ.

ДЭЛХИЙ

АНУ 2017 онд 3үүн өмнөд Ази, Ойрх дорнодоос 110 мянган дүрвэгч хүлээн авна.

Нью-Йорк хотноо НҮБ-ын 71 дэх удаагийн Ерөнхий ассамблей хуралдаж байна.

Ливид явуулсан байлдааны ажиллагаатай холбогдуулан Дэвид Кэмероныг шүүмжлэв.

Вашингтон ОХУ-д тавьсан хоригийнхоо заримыг цуцаллаа.

Гэрийн тоос багтраа, үргүй- дэл, хорт хавдар үүсгэх магадлалтайг эрдэмтэд тогтоов.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2016.09.15

°18 | °7

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРЖИГҮЙ МЭДЭЭЛИЙГ 7 ДУГААР НҮҮРЭЭС УШИВНА УУ.

9 638 000 029112 00476

Бүхэрх хуулиар хамгаалагдана ©

Барилгын салбарыг чирж буй ипотека



Орон сууцны үнийн хөөсрөл хагарч, барилгын салбар санхүүгийн хүндрэлтэй золгоод байна. ► 11

Б.Ганбаяр / ЗГМӨ

ЗГМ: СУРВАЛЖЛАГА

Тоглохыг хориглоно

Г.Сайнзаяа @sainzayaZGM

Тоглоомын талбай хүүхдүүдийн тоглож наадаг бүс болохоос бэртэж гэмтдэг, дахин зүглэхээс айдаг газар байх учиргүй. Үнэндээ манай тоглоомын талбайнууд ихэвчлэн сонгуулиар зүс орж, эсвэл шинэ орон сууц баригдахад дагаж босдог жамтай.

Шинэдээ бол тун гоё. Цэнхэр, шар, улаан гээд тод өнгийн хослол, төрөл бүрийн дасгал хийх, бас тоглох сонголттой. Зарим талбайн хажууханд нь бяцхан усан оргилуур барьсан ч харагддаг. Гэвч удалгүй л энд тэндээс нь ёрдгор төмөр гозойж, далийсан, хугарсан, салаад уначихсан сэг болж үлддэгийг хэн бүхэн мэднэ.

► 3

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

Санхүүгийн сахилга батад онцгой анхаарах цаг ирсэн

Б.Даваагтох @datoZGM

УИХ-ын ээлжит бус чуулганаар 2016 оны төсвийн тодотгол болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг баталсан. Энэ талаар УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалантай ярилцлаа. -УИХ-ын ээлжит бус чуулганаар 2016 оны төсвийн

тодотголыг хэлэлцлээ. 4.4 их наяд төгрөгийн алдагдалтай байсан төсвийн тодотголд УИХ багагүй засвар хийсэн. Батлагдсан төсвийн тодотголд ямар байр суурьтай байгаа вэ? -Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал туйлын хүнд байгааг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй.

► 2



Тамирчдын мэдээллийн хулгайд оросууд буруутай юу

Мурад Ахмед

Дэлхийн сэргээшийн эсрэг агентлаг (WADA) Риогийн олимпод оролцсон тамирчдын хувийн мэдээллийг хулгайлсан хэрэгт ОХУ-ын кибер тагнан турших бүлгийг буруутгалаа. Засгийн газрын оролцоотой сэргээшийн хэрэг илэрсэнтэй холбогдуулан уг бүлэг өс авах


зорилгоор дээрх халдлагыг үйлдсэн хэмээн тус агентлаг үзжээ. WADA-гийн өгөгдлийн санд нэвтэрч АНУ-ын тамирчидтай холбоотой баримтыг нийгэлсэнэ Fancy Bears' Hack Team нэртэй уг бүлэг мягмар гарагт мэдэгдсэн.

► 10

ЗГМ: ИНФОГРАФИК

ДЭЛХИЙН ҮҮРЭН ХОЛБООНЫ ЗАХ ЗЭЭЛ

2016 оны зургадугаар сарын байдлаар



Дэлхий даяар 7.46 тэрбум үүрэн телефон хэрэглэгч байна. Үүрэн утас хэрэглэгчийн тоо дэлхийн хүн амын тооноос их



OVUM ©

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
822.75 0.65%	1320.20 1.80%	4626 0.02%	90.04 0.053%	97.74 0.023%	2240.74	335.91	34.46

Улс төр

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

Санхүүгийн сахилга батад онцгой анхаарах цаг ирсэн

Хүнд үед татвараар төсвийн орлогыг бүрдүүлэх нь оновчтой шийдэл биш

«1 Ийм хүндхэн үед Засгийн газар төсвийн тодотголыг оруулж ирсэн. Эдгээр төсөл хөтөлбөрөөс ямар ч байсан найман төрлийн татвар нэмэхтэй холбоотой асуудлыг татаж авлаа. Дээр нь зарим нэг зардлыг танасныг буцааж тависан. Тухайлбал, төрийн зарим албан хаагчид олгодог 36 сарын цалингийн нэмэгдэл байлаа. Цэргийн албан хаагчдын нөхөн олговрыг хасахааргүй боллоо. Гадаадад сурч байгаа оюутнуудын цалин, тэтгэмжийг хасахаар төсөл оруулж ирсэн. Үүнийг ч мөн хэвийн явуулна. Түүнчлэн Төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтаа нэмэхээр түлхүү ярьж байна.

-УИХ дахь МАН-ын бүлгийн гишүүд төсвийн тодотголд багагүй шүүмжлэлтэй хандаж, найман төрлийн татвар нэмэх саналыг эргүүлэн татах шийдвэр гаргасан. Орон нутгийн сонгууль болохтой холбогдуулан ийм шийдвэр гаргалаа хэмээн шүүмжлэх хүн цөөнгүй байна?

-Төсвийн алдагдлыг бууруулахын тулд Засгийн газар татвар нэмэх саналыг гаргасан. Гэтэл энэ саналыг зарим хүн багагүй улстөржүүлэх шиг боллоо. Өөрөөр хэлбэл, МАН ард түмнийхээ халаас руу гар дүрж байна, амлалтаасаа



Б.Ганбаяр / ЗГМ

буцаж байна. Олон хүнийг ажилгүй болгох нь гэж ярилаа шүү дээ. Эцсийн дүндээ бид аль болох хэмнэлттэй л ажиллах ёстой.

Гэхдээ энэ хүнд үед татвараар төсвийн орлогыг бүрдүүлэх нь оновчтой шийдэл биш гэж үзсэн. Тэгээд ч татварын орлогоос тийм их

хэмжээний мөнгө төвлөрөхгүй. Тийм учраас үүний оронд хариуцлагын асуудлыг сайн ярь. Өөрөөр хэлбэл, үргүй зарсан мөнгийг эрж хайя гэж байгаа юм.

-Тэтгэвэрт гарч буй төрийн албан хаагчдад олгодог 36 сарын тэтгэмжийг хасах асуудал нийгэмд багагүй маргаан дагуулсан. УИХ-ын дарга уг тэтгэмжийг үргэлжлүүлэн олгох үүргийг Засгийн газарт оглоо. Та үүнд ямар байр суурьтай байгаа вэ?

-Тушаалаар амьдардаг буюу цол, мөрдөстэй хүмүүсийн тэтгэмжээр амьдрал ахуйгаа гэдэг байр суурийг би анхнаасаа илэрхийлсэн. "Монгол Улсын төлөө зүтгэе" гэсэн тангарагтай хүмүүсийг Монголын төр орхиж болохгүй. Цалин, хангамжийн хувьд өндөр биш шүү дээ. 36 сарын тэтгэмжээр амьдрал ахуйгаа залгуулдаг хүмүүс ч бий. Энэ бол Монгол Улсын төлөө зүтгэснийх нь төлөө төрөөс өгч байгаа нөхөн олговор. Тиймээс үүнийг бид хасаж болохгүй. Ингээд эцэст нь бид эдийн засаг хүндрэлтэй байгаа үед хэдэн төрийн албан хаагчаа торгож, 36 сарын тэтгэмжийг нь хасахгүй, хэвээр үлдээх шийдвэр гаргалаа.

-Монгол Улсын өрийн босго хэдийнэ хуулийн хязгаар давчхсан. Цаашдаа энэ босгыг хязгаарлах тал дээр ямар арга хэмжээ авах вэ?

-Бидэнд өгч байгаа мэдээлээр өрийн босго 80 хол гарсан гэж байна. Гэхдээ эцсийн байдлаар тодорхой тогтоогдохгүй байна. Учир нь төсөв нэгдсэн байгаагүй.

Дөрвөн өөр төсөвтэй байсан учраас нэгдсэн тоо гардаггүй. Одоо бид энэ бүхнийг нэгтгээд эцсийн байдлаар тооцоо гаргах хэрэгтэй байна. Ингэхгүй бол зарим нь өөртөө зориулж тоо зохиочихоод яваад байна шүү дээ. Цаашдаа нэгдсэн тоог

Их хүнд нөхцөлд, татуу төсвийг тал бүр тийш хүргэх гэж ихэд хичээлээ

гаргасны дараагаар хэрхэн буулгах, хуулийн хэмжээнд барих талаар анхаарч ажиллахаас өөр гарцгүй.

-УИХ-ын ээлжит бус чуулганы үр дүнг та хэрхэн дүгнэж байна вэ?

-Ээлжит бус чуулган хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлуудаа эцэслэсэн. Их хүнд нөхцөл байдалд, татуу төсвийг тал бүр тийш хүргэх гэж эхийг нь эцээж, тугалыг нь тураахгүй байх гэж л үзлээ дээ. Ямар ч байсан үүргээ гүйцэтгэлээ гэж бодож байна. Гэхдээ бид цаашдаа их хариуцлагатай ажиллах, Монгол Улсын санхүүгийн сахилга батад онцгой анхаарах цаг ирж байна.

Энд нэг зүйлийг тодотгож хэлэхэд, Ардчилсан намынхан бүх зүйл сайхан байгаа л гээд байсан. Гэтэл булавч бултайж, даравч далдайна гэдэг болж байна. Бодит байдлыг нь бид хангалттай харлаа. Одоо бид эрүүлээр сэтгэх ёстой. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» **АЙЛЧЛАЛ**
Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн Бүгд Найрамдах Куба улсад хийж буй албан ёсны айлчлал эхэллээ. Айлчлалын хүрээнд тэрбээр тус улсын Төрийн болон Сайд нарын зөвлөлийн даргатай хэлэлцээ хийнэ. Мөн Гаванагийн их сургуульд зочилж, Монголын түүх, соёл болон нийгэм, эдийн засгийн байдлын талаар лекц унших аж.

» **ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

Засгийн газраас ирсэн захиалгын дагуу Төрийн албаны зөвлөл хэдэн агентлагийн даргын сонгон шалгаруулалт хийнэ. Тухайлбал, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын сонгон шалгаруулалтыг энэ сард багтаан зарлана. Харин бусад 10 агентлагийн даргын бүртгэлийг ирэх сард хийхээр төлөвлөжээ.

» **ТОО**

4800

Хүүхэд. 1998 оноос хойш хилийн чанадад 4800 монгол хүүхэд төржээ. Үүнээс 2181 хүүхэд Монгол Улсын хууль үйлчлэхээс гадна тухайн оршин суугаа улсын хууль үйлчилдэг аж. Мөн тухайн улсын иргэнээр тооцож, бүртгэсэн байна.

» **УУЛЗАЛТ**

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат "Оросын төмөр зам" нийгэмлэгийн тэргүүн Олег Белозёровтой уулзлаа. Уулзалтаар УБТЗ-ыг одоогийн хувь нийлүүлсэн нийгэмлэг хэлбэрээр нь хадгалаад явах уу, эсвэл зах зээлийн онцлогт тохируулан компанийн засаглалын хэлбэрээр шинэ түвшинд гаргаж хөгжүүлэх үү гэдэг дээр хоёр тал шийдвэр гаргах цаг болсныг Олег Белозёров онцлов.

» **ПАРЛАМЕНТ**

УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүд Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцлаа. Энэ үеэр Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль 2012 онд батлагдсан боловч журам нь одоо хүртэл гараагүйгээс бохирдуулагч үйлдвэрүүдтэй хариуцлага тооцох боломжгүй байгааг Ус сувгийн удирдагч газрын дарга Ц.Төрхүү тайлбарлалаа.

» **НАМУУД**

Ардчилсан намын ҮЗХ маргааш хуралдана. Энэ удаагийн хурлаар 2016 оны УИХ-ын ээлжит сонгуулийн ялагдлын шалтгаан болон бусад асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсөн. Харин Их хурлаа арванхоёрдугаар сарын 6-нд хийхээр тогтсон билээ.

» **ХАМТЫН АЖИЛЛАГАА**

"Нортерн Рэйлвейс" компани Монголын хойд бүс нутгийн уул уурхай, газар тариалан болон аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд дэд бүтцийн чиглэлээр томоохон хөрөнгө оруулалт хийхээр болсноо Засгийн газарт дуулгалаа. Тус компани нь Эрдэнэт-Овоотын чиглэлийн 547 километр төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг авсан юм.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» **OPED@ZASAG.CO**

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ

Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчид өнөөдөр хуралдана

Б.Тогтох
ЗГМ

Ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан нийслэлийн ИТХ хуралдааны дэгээ эрчин хоёр сар гаруйн хугацаанд хуралдаагүй байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дэгийн дагуу нийслэлийн ИТХ долдугаар сарын 28, наймдугаар

25-нд хуралдах ёстой аж. Иймд нийслэлийн ИТХ-ын ээлжит бус хуралдааныг есдүгээр сард багтаан хуралдуулахыг Ардчилсан намын бүлэг шаардсан.

Тэгвэл нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг өнөөдөр товлосныг нарийн бичгийн дарга М.Буяндэлгэр мэдэгдлээ. Тэрбээр "Нийслэлийн ИТХ-ын анхдугаар хуралдаан долдугаар сарын 6-нд болсон. Анхдугаар

хуралдааны шийдвэрээр Тэргүүлэгчдийг сонгох тогтоол гарч, томилогдсон. Одоо хэвийн үйл ажиллагаагаа явуулж байгаа. Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал нийтдээ таван удаа хуралдаж, 19 асуудал хэлэлцэн, 17 тогтоол шийдвэр гаргасан. Харин нийслэлийн ИТХ-ын нэгдсэн хуралдаан дэгийн дагуу сар бүрийн сүүлийн долоо хоногийн пүрэв

гарагт хуралддаг. Ажлын болон дэд хороод бол нийслэлийн ИТХ-ын үндсэн дотоод зохион байгуулалтын нэгж. Нийслэлийн ИТХ-ын хоёрдугаар хуралдаан наймдугаар сарын сүүлийн долоо хоногт хуралдах ёстой байсан ч хойшлогдсон.

Шалтгаан нь нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн наймдугаар сарын 17-ны 11 тоот тогтоолоор ажлын болон

дэд хороодын бүтэц хэд байхыг шийдвэрлэсэн. Намын бүлгүүд иргэдийн хурлын төлөөлөгчдөө өөр өөрийн харьяалагдах хороонд ирүүлэх ёстой. Үүний дараа Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх ёстой байдаг. Өнөөдөр нийслэлийн ИТХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга Ц.Баатархүү энэ саналаа албан бичгээр ирүүлсэн" гэв. [ЗГМ]

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Барилгын тусгай зөвшөөрөлтэй компаниудад шалгалт хийнэ

Барилга угсралтын тусгай зөвшөөрөлтэй 4749 аж ахуйн нэгж бий

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат салбар салбарын төлөөлүүдтэй уулзан санал бодлыг нь сонсож байгаа. Энэ удаад барилгын салбарын төлөөлөлтэй уулзав. ДНБ-ий өсөлтийг дангаараа хангаж чадахуйц байсан барилгын салбарын үйл ажиллагаа доголдож, уналтад орсон. Иймд үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлд хэд хэдэн саналыг Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан гэдгийг Ерөнхий сайд уулзалтын эхэнд онцоллоо.

Уулзалтын үеэр Монголын барилгачдын холбооноос аймаг бүрт 1000 айлын орон сууц болон нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг

үргэлжлүүлэх хүсэлт тавив. Мөн барилгачдыг бүртгэлжүүлэх, чадваржуулах чиглэлд олон улсын байгууллагатай хамтарч төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд Засгийн газраас дэмжлэг хүслээ. Харин уулзалтад оролцсон зарим төлөөлөл гэр хорооллын дахин төлөвлөлтөөс илүү дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэж, иргэд өөрийн газартаа тохилог амины орон сууц барих боломжийг бүрдүүлэх нь чухал гэдгийг сануулсан юм.

Монголын барилгын үндэсний ассоциациас ипотекийн зээлийг үргэлжлүүлж, орон сууцыг эргэлтэд оруулах шаардлагатайг онцоллоо. Учир нь өнөөдрийн байдлаар ашиглалтад бүрэн орсон найман мянган орон сууц байгаа аж. Мөн 50-иас дээш хувийн гүйцэтгэлтэй 25 мянган орон сууц хүлээлгэгдэж байгааг дуулгалаа. Үүнээс гадна Түрээсийн орон сууц хөтөлбөрийг үргэлжлүүлэх хүсэлтийг ч тавьсан.

Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо дотоодын

компаниудыг төр бодлогоор дэмжихийг хүсэв. Учир нь гаднын хөрөнгө оруулалттай зарим компани дотоодоос бүтээгдэхүүн авдаггүй бөгөөд өөрсдийн улсаас барилгын материалаа оруулж ирдэг аж. Энэ сүлжээг задалж, тодорхой хувьд нь дотоодод үйлдвэрлэсэн барилгын материал ашигладаг болгох, барилгын материал үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлөх асуудлыг судлах саналуудыг хэлсэн юм. Мөн түгээмэл тархацтай ашигт малтмалын зөвшөөрөл хамгийн их тулгамдаж байгаа асуудал болсон гэдгийг энэ үеэр тодотгов.

Үүнээс гадна газар эзэмшиж, ашиглах эрх авсан этгээдүүд дамлан зарж буйг таслан зогсоох шаардлагатай аж. Хуулиараа газар эзэмшиж, ашиглах эрх аваад хоёр жилийн хугацаанд ямар нэгэн байдлаар ашиглаагүй бол улс эргүүлэн авдаг юм.

Түүнчлэн барилгын салбарт бүтээмж, чанар аюулгүй

Ашиглалтад бүрэн орсон найман мянган орон сууц байна

байдлыг нэмэгдүүлэх ухаалаг тогтолцоог, компаниуд төслийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх шаардлага гарсныг уулзалтад оролцогчид хэлж байлаа. Зогсонги байдалд орсон барилгуудыг үргэлжлүүлэх, хилийн чанадад амьдарч байгаа монголчууд эх орондоо ипотекийн зээлээр орон сууц худалдан авах боломжийг бүрдүүлэх, гаднын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг саналыг салбарын сайдад уламжлав.

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон түрээсийн орон сууц, ипотекийн зээлийн хувьд тодорхой өөрчлөлтүүд хийнэ

гэдгийг уулзалтын төгсгөлд онцолсон юм. Мөн 2012 онд барилга угсралтын тусгай зөвшөөрөлтэй 1831 аж ахуйн нэгж байжээ. Харин 2016 онд 4749 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл авсан байна. Тусгай зөвшөөрлийг судлах ажлыг удахгүй эхлүүлнэ. Энэ бол дарамт биш, төрийн зохицуулалтаар хийгдэж байгаа ажил гэж хүлээж авах хэрэгтэй. Өнгөрсөн хугацаанд барилгын салбарт хамгийн их хөрөнгө оруулалт хийгдсэн. Гэвч эрэлтээ тооцолгүйгээр нийлүүлэлт хийсэн нь энэ салбарыг уналтад оруулах гол шалтгаан болсон гэж хэллээ.

Эхний ээлжинд ажил нь зогссон барилгуудыг судалж, шийдвэрлэнэ. Судалгаа хийж, эх үүсвэрээ тооцож, бодлогоо боловсруулж ажиллана. Хилийн чанадад амьдарч байгаа иргэд эх орондоо зээлээр орон сууц худалдан авах боломжийг бүрдүүлэхийг мөн судална гэдгийг Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат онцолсон юм. [ЗГМ]

ЗГМ: Сурвалжлага

Гадна талбайн тоглоомууд элэгдэж, эвдэрсэн, шал нь хатуугаас хүүхдүүд бэртэж байна

ярихаас аргагүй. Стандарт бүхий тоглоомын талбайн шал нь элс, зөөлөн шороо, эсвэл резинэн зөөлөвтэй байдаг. Түүнээс биш манайх шиг хатуу цемент, чулуун хавтан дэвсчихээд “Унасных нь хохь” гээд сууж байдаггүй.

41 Гозойж үлдсэн хэд нь бүр социализмын үеийн, хээр талд аянга, цахилгаан хураадаг станц уугэлтэй зэвэрсэн төмөр л байна. Өнгө, үзэмж нь байг гэхэд хүүхдэд аюулгүй байх хэрэгтэйг олон эцэг, эх хэлдэг. Фэйсбүүк дэх 27 мянга гаруй гишүүнтэй эцэг, эхчүүдийн группт явуулсан бэсрэг судалгаагаар 90 хувь нь гадна тоглоомын талбайг аюултай, сонголт муутай, ихэнх тоглоом нь эвдэрсэн учир сэтгэлд нийцдэггүй гэж хариулсан юм. Тиймээс бид хүүхдийн талбайн тоглоомуудын аюулгүй байдлыг хөндлөө.

Юм бүхэнд гаднын жишиг татах дэмий. Гэхдээ гадна тоглоомын талбай дээр бол

Сүүлийн үед хийгдсэн зарим талбайн гадаргуу зөөлөвтэй болсон. Гэсэн хэдий ч Гэмтэл согог судлалын үндэсний төвд гадна тоглоомын талбай дээр тоглож байгаад гэмтэж бэртсэн гэх хүүхэд байнга ирдэг. Өнгөрсөн оны аравдугаар сарын 1-нээс энэ оны есдүгээр сарын 1-нийг хүртэлх хугацаанд нийт 177 хүүхэд тоглоомын талбайд гэмтэж, тус төвд ханджээ. Тэднээс 10 нь гавал тархины гэмтэл авч, 70 хүүхдийн яс хугарсан байна. Харин үлдсэн 97 нь шарх болон бусад зөөлөн эдийн гэмтэл авсан талаар ГССҮТ-ийн Статистик тандалт судалгааны албанаас мэдээлэв. Мөн тоглоомын талбай дээр гэмтсэн хүүхдүүдийн дийлэнх нь савлуураас шидэгдсэн, савлуурт цохигдсон болон гулгуураас

Тоглохыг хориглоно



Б.Ганбаяр / ЗГМ ©

ЗГМ: ИНФОГРАФИК



унаж бэртдэг гэлээ.

Гадна талбайн тоглоомын аюулгүй байдлыг эзэмшигч нь хуулиар хариуцлага хүлээх тухай хууль ч бий. Талбайн бүх тоглоом аюулгүй байлаа ч хүүхэд бэртсэн л бол эмчилгээ, эм, эмнэлгийн гадаах зогсоолын төлбөрөөс эхлээд эцэг, эх нь хүүхдээ асрах хугацаанд алдсан шалинг хүртэл нөхөн олгодог ажээ. Харин манайд “Өөрөө унасан хүүхэд уйлдаггүй юм” гэдэг бичигдээгүй ганц хууль л үйлчилж байна. Уг нь талбайн тоглоомууд эвдэрсэн, ашиглалтын хугацаа дууссан тохиолдолд хүүхэд бэртсэн бол наад зах нь хэн нэгэн нь хариуцлага хүлээдэг баймаар.

Сүхбаатар дүүргийн Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн дарга Ц.Баттөмөр “Бид хүүх-

дийн талбайн тоглоомыг тендер зарлаж, журмын дагуу авдаг. Аюулгүй байдал болон чанарыг нь харин өөрсдөө шалгадаг. Энэ төрлийн тоглоом барилгын хуулийн дагуу гурван жилийн баталгаатай байх шаардлагатай. Эвдрэл гарсан тохиолдолд зайлшгүй засуулж байгаа” гэсэн юм.

Монголд гадна талбайн тоглоом, чийрэгжүүлэх төхөөрөмж нийлүүлдэг тоотой хэдхэн буюу тав орчим компани байдаг аж. Тэдний нэг болох “Grand Creative” группийн менежер Б.Гончигдорж “Бид бүтээгдэхүүнээ ихэвчлэн захиалгаар нийлүүлдэг. Компанийн зүгээс зөвхөн угсарч, хүлээлгэж өгдөг” хэмээлээ. Түүнчлэн баталгаат хугацаа

олгодоггүй бөгөөд эвдэрсэн шалтгаанаас хамааран засаж, сольж өгөх тохиолдол бий. Тус компани хил, гааль дээр бүтээгдэхүүнийхээ олон улсын ISO:9001, ISO:14000 стандартын гэрчилгээг шалгуулдаг. Харин дараагийн шалгалтыг хүлээн авагчид хийдэг ажээ.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас энэ талаар лавлалат “Гадна талбайн тоглоомд тодорхой хяналт шалгалт хийдэггүй. Зөвхөн эрүүл ахуйн үүднээс тоглоом хоорондын зай зэргийг л зөвлөдөг” гэв. Энэ мэтчилэн хүүхдийн тоглоомын чанар, аюулгүй байдалд тавих хяналт шалгалт дутагддаг нь харагдаж байна. Харин бусад орон энэ асуудалд онцгой анхаардаг. Хяналтын

тусгай алба ажиллахаас гадна аюулгүй байдал, ашиглалт зэргийг байсхийгээд шалгаж, тайлагнадаг юм байна. Иргэдээ, бяцхан үрсээ анхаарч буй төрийн халамжийн нэг энэ.

Сонирхуулахад, нэг тоглоомын талбайд гурван төрлийн тоглоом, нэг сүүдрэвч, хоёр ширхэг хогийн сав, дөрвөн сандал байрлуулахад ойролцоогоор 10 сая орчим төгрөг болдог аж. Гэхдээ энэ бол хамгийн хямд төсөв.

Идэвхтэй, хөдөлгөөнтэй хүүхдүүд чийрэгжиж, өвчин тусах нь ховор. Тиймээс ч тоглож наадах талбай нь тохилог хийгээд аюулгүй байх талд тавьдаг хяналтын тогтолцоог одооноос бүрдүүлэх нь чухал гэдгийг албаны хүмүүс анхааруулж байна. [ЗГМ]



Тэнцвэртэй мэдээллийг Танд

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИНЫ IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА. ЗАХИАЛГЫН ҮНЭ: 30,000₮



УЛИРАЛД

64 ДУГААР



Блю Скай тауэр, 4 Давхар, № 407, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс, И-мэйл: info@zasag.co Утас: +976 70103131, Факс: +976 70106065, Вэб: Zasag.Co

Технологи

Математик бол “гавлуудын” бяд хүрэх хичээл гэдэг ойлголт ард хоцорно

З.Цэлмэг
@tselmegZGM

Оюуны гимнастик болсон математикийг зугаатай байдлаар сургах цахим математикийн “Mathshop 1.0” программыг ирэх оноос худалдаанд гаргахаар болжээ. Цэцэрлэгийн бэлтгэл ангийнхнаас эхлээд их, дээд сургуульд элсэгчид төдийгүй нийт масс ч математикийг зугаатай байдлаар суралцах боломжтой “Mathshop 1.0” программыг арваннэгдүгээр сараас тестлэх аж.

Нийт 14 бүлэгтэй энэхүү программыг монгол, англи хэлээр хөгжүүлжээ. Тэрчлэн Монголын суурь боловсролын тогтолцоонд нийцүүлснээрээ онцлог гэдгийг “Mathshop 1.0” төслийн санаачлагч, математикч доктор П.Лхагвасүрэн онцлов. “Харин нэгэнт татаж авсан л бол интернэтийн орчин шаардахгүйгээрээ уг программ бусдаас давуу талтай” хэмээн “Mathshop 1.0”-ийг хөгжүүлсэн МОСС компанийн захирал Л.Түмэндэлгэр хэлж байна.

“Mathshop 1.0” программын математикийн онол болон сорилын өгөгдлүүдийг салбартаа толгой цохидог Ү.Маам зэрэг ардын багш нар боловсруулж, зөвлөхөөр нь ажилласан байна. Уг төсөл үндсэндээ 2010 оноос программ хангамжийн МОСС компанийн програмистуудын гараар хөгжиж буй бөгөөд 2013 онд эхний хувилбарыг нь гаргаж байжээ. Тухайн үед туршилтын журмаар 100 хувиан, бүгдийг нь нэг зэрэг ажиллуулахад гацаж, интернэт орчинд ажиллах нь дэмий гэдэг дүгнэлтэд хүрчээ. Тиймээс өнгөрсөн гурван жилийн хугацаанд интернэт орчин шаардахгүйгээр ажиллахаар хөгжүүлсэн талаар төслийн удирдагч тайлбарласан. “Mathshop 1.0” программд инновацийн хэд хэдэн шийдэл



“Mathshop 1.0” программын математикийн онол болон сорилын өгөгдлүүдийг салбартаа толгой цохидог Ү.Маам зэрэг Ардын багш нар боловсруулж, зөвлөхөөр нь ажилласан байна.

NYT©

Зугаатай гимнастикийг цэцэрлэгээсээ

Одоогоор “Windows 7”-гоос хойших үйлдлийн системд ажиллана

бичихээ больсон цаг үед бид амьдарч байна. Гэтэл “Mathshop 1.0” программ бол олон бодлогыг хэзээ ч уйдаагүйгээр бодох боломжтойгоороо ололттой” хэмээв. Мөн программ дээр хичээллэж байгаа хүүхдүүд хэд л бол хэдээрээ интернэтээр

хоорондоо холбогдож тоо бодолтын өрсөлдөөн өрнүүлэх нь сурагчид математикийг зугаатай байдлаар суралцах нэг боломж болж байна. Хэрэглэгч ямар ч бодлогын хариуг нэгээс хоёр үйлдлээр л гаргана. Ингэснээр мэдлэг эзэмших явцад үүсдэг залхах сэдлийг эрс бууруулж буй аж.

“Mathshop 1.0” программын 14 бүлэг тус бүрт тухайн түвшинд заавал үзсэн байх ёстой хичээлийн сэдвүүдийг багтаажээ. Нэгдүгээр ангийн сурагчдад зориулсан бүлэг гэхэд “тоо тоолол”, “нийлбэр, ялгавар”, “үржих, хуваах” гэх мэт сөн дэд сэдэвтэй. Сэдэв нь онолын хэсэг,

сорилын хэсэг, тусламж гэсэн гурван үндсэн бүрэлдэхүүнээс бүрдэнэ. Тухайлбал, систем тэгшитгэлийн сэдвийн онолын хэсэгтэй танилцсаныхаа дараа сорилыг энгийнээс эхлээд хүндэрсэн гурван түвшинд бодно. Хэрэв бодож чадахгүй бол сэтгэлээр унах хэрэггүй гэнэ. Эцэг эх, багш тэр ч бүү хэл мундаг математикийг орлох хэмжээний боловсролгүй зөвлөгч болох тусламж хэсгээс сурагч хэрхэн бодох аргачлалаа олж авах юм байна. Ийнхүү алдаатай бодсон ч чухам юун дээр алдсан гэдгийг нь тайлбарлах функцтэй. Нэг түвшнийх л гэхэд 1000 бодлогын

өгөгдөлтэй бөгөөд давтагдашгүй мөчлөгтэй.

“Хэдий энэ нь ЕБС-ийн сургалтын стандарттай уялдан, цэцэрлэгийн бэлтгэл бүлгээс ЭЕШ-ын түвшнийг хамарсан ч багш, эцэг эх, эмээ өвөө, ах эгч гээд бүх л хүнийг оролцуулах боломжтой. Иймд нийт массын математикийн боловсролыг дээшлүүлэх чухал ач холбогдолтой үзэгдэл болно” хэмээн төслийн санаачлагч тайлбарлалаа.

Тус программ одоогоор “Windows 7”-гоос хойших үйлдлийн системд ажиллах бөгөөд MAC OS-д зориулсан хувилбар нь хараахан гараагүй байна.[ЗГМ]

Үйл явдал “Sony” VR технологид ноёлж байна



“Sony” компани “PlayStation VR”-ийн VR хувилбар бүхий PS4 консолын толгойн өмсгөлөө товлоосон аравдугаар сараасаа урьтаж Токиогийн тоглоомын шоу дээр танилцуулсан нь олны анхаарлыг татжээ. Энэ онд 20 жилийн ойгоо тэмдэглэж буй Компьютер энтертаймент ханган нийлүүлэгчдийн нийгэмлэг үзэсгэлэнд дэлгэгдэж буй VR буюу виртуаль бодит байдлын бүтээгдэхүүнүүдэд талбай гаргаж өгчээ. Энэ нь энэхүү шинэ технологи тоглоомын салбарт хэр зэрэг орон зай эзэлж буйг тандах гэсэн зориудын үйлдэл байв.

Токиогийн энэ жилийн тоглоомын шоу үзэсгэлэнд гадаад, дотоодын нийт 600 гаруй үзүүлэгч 1000 орчим шинэ тоглоом дэлгэжээ. Ингэснээрээ түүхэнд хамгийн олон үзэгчтэй жилээр тэмдэглэгдэн үлдэв.

Компьютер энтертаймент ханган нийлүүлэгчдийн нийгэмлэгийн мэдээгээр “Sony”-гийн PS4 консол одоогоор 43 сая ширхэг зарагдаад буй аж. Тиймээс ч “Moog Insights & Strategy”-ийн тэргүүн болоод шинжээч Патрик Мурхэд VR технологийг олны хэрэглээ болгосон хамгийн анхны компаниар “Sony”-г зарласан. Тэрбээр одоогийн толгойн

өмсгөлүүд “Sony”-гийн дайнд хүрэхгүй байгааг онцолжээ. Өрсөлдөгч болох “Oculus Rift”-ийн байдал сайнгүй байгаа бол “Samsung Gear” нь VR технологийн тод илэрхийлэл болж хүчрэхгүй ухаалаг утаснаас хэт хамааралтайг Мурхэд тайлбарлалаа.

“PlayStation VR”-ийн ид шид тоглоом төдий хязгаарлагдахгүй. Театрын амьт тоглолтыг үзэж болохоос гадна түүх дурсгалын газраар VR технологийн тусламжтай очиж, хөгжим сонсох, видео үзэх зорилгоор ашиглах боломжтой. Энэ талаар “Sony” компанийн Япон, Азийг хариуцсан ерөнхийлөгч Ацүши Морита “VR платформыг хөгжүүлж, орлогын гол эх үүсвэрээ болгохоор зорьж буй бидний хувьд видео, хөгжмийн контентод эрчтэй орж байгаа нь эерэг зүйл” хэмээв. “PlayStation VR”-ийн жижиглэнгийн үнийг 400 ам.доллараар тогтоохоор төлөвлөж буй нь өрсөлдөгч болох 600 ам.долларын үнэтэй “Oculus Rift” болон 800 ам.долларын үнэтэй “HTC Vive”-аас мэдэгдэхүйц хямд юм.

Гурван өдөр үргэлжлэх энэ жилийн шоууд “Bandai Namco”, “Capcom” болон “Sega” зэрэг тоглоомын зах зээлийн гол тоглогчид VR тоглоомуудаа танилцуулах юм байна. Харин “Nintendo” болон “Microsoft” оролцсонгүй. Бүтээлээ дэлгэгчдийн хувьд VR технологид суурилсан бүтээгдэхүүний зах зээлийг хөгжүүлж чадах, эсэх нь хамгийн том асуулт болон гарч ирж буй аж. Өөрөөр хэлбэл, одоогийн тоглоомыг дахин нэг шат ахиулахын тулд салбарынхан багагүй сорилттой тулгарна.[ЗГМ]

СУДАЛГАА Канадчуудын талаас илүү нь тоглоомчин

Хэдийгээр “Samsung” компани “Galaxy Note 7” брэндээсээ болж багагүй хүндрэлд орсон ч амархан халж, улмаар шатдаг тус брэнд канадчуудын гар утсаараа тоглох зуршлыг нь өөрчлөхгүй бололтой.

Насанд хүрэгчдийн 41 хувь нь видео тоглоом тоглохдоо гар утсаа нэн түрүүнд шүүрч авдаг нь Канадын Энтертаймент программ хангамжийн нийгэмлэгээс сүүлд явуулсан

судалгаагаар тогтоогдов. Энэ нь дөрвөн жилийн өмнөхөөс зургаан хувиар өссөн үзүүлэлт юм байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 52 хувь нь сүүлийн дөрвөн долоо хоногт хамгийн багадаа нэг удаа видео тоглосон гэж харуулжээ. Энэ давтамж бол “тоглоомчин” гэх гуншинг бүх хангалттай үзүүлэлт гэдгийг Энтертаймент программ хангамжийн нийгэмлэг онцоллоо. Үүнийг нотлох

өөр нэг дүн бол судалгаанд хамрагдагсдын 38 хувь нь өөрсдийгөө тоглоомчин гэдгээ хүлээн зөвшөөрсөн аж.

Судалгааны үр дүнд илэрсэн өөр нэг сонирхолтой баримт нь эмэгтэйчүүд эрчүүдээс илүү гар утасны тоглоомд “донтох” хандлагатай болж буй явдал. Гар утсаараа өдөрт хамгийн багадаа нэг удаа тоглодог эмэгтэйчүүд эрчүүдээс есөн хувиар илүүрхжээ.[ЗГМ]



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ
СОНИН АНХ

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургалч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН
Ерөнхий эрхлэгч
Цэвэлэгийн МӨНХЖИН
Нэгдүгээр орлогч эрхлэгч
Цэвэлэнголорын ЦЭВЭЭНХЭРЛЭН
Утас: 99901526
Хоёрдугаар орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483
Эдийн засаг, бизнес мэдээлэл, дизайн, гэрэл зургийн алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621
Соёл энтертаймент, гадаад контентын алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901682

ЗАР СУРТАЛЧИЛГАА
Г.Лхагвасүрэн
Утас: 99903581

ХАЯГ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Бло Скай таур” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР
Zasag.Co
“Чөлөөт хэвлэл”
сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв
Дугаарын удирдагч
Ц.Цэвэнхэрлэн

70103131, 99903581, 99903584
info@zasag.co
Zasag.Co

986 580000 4291124 00476

Урлаг



Б.Ганбаяр / ЗГМ

Диваажин дахь бүжиг

“Антарктика панорама” шүүмжлэлтэй, бас гунигтай

Б.Бямбасүрэн
@byambaZGM

Үсгүй хэрнээ нүцгэн охид цэв цэнхэр “тайзнаа” бүжиглэнэ. Тэдний зарим нь балет, чөлөөт бүжгийн хөдөлгөөн хийж буй бол нөгөө хэсэг нь зүгээр л

дээшээ үсэрч, ямар нэгэн зүйл рүү тэмүүлэх мэт. Царай төрхийг нь анзаарвал инээмсэглэх үгүйн хооронд ажээ. Гагцхүү хийж байгаа тэрхүү бүжигтээ л охид бүхий л анхаарлаа төвлөрүүлсэн гэлтэй.

Бүжиглэж буй охидтой хамт цагаан өнгийн хотон шувууд бүжнэ. Шувуудын ихэнх нь бас л ямар нэг зүйл рүү ширтсэн байх агаад зарим нь амаа томоос том ангайх аж. Уран бүтээлч өөрийн сэтгэл хөдлөлөө дээрээс доош урсан цагаан зураасаар илэрхийлсэн нь хөшигний цаана өрнөх диваажинг илтгэнэ. Энэ бол зураач Э.Отгонбаярын Blue

буюу “Цэнхэр” хэмээх зураг. Тэр энэ зургаараа диваажинг илэрхийлэхийг зорьжээ. Түүний бүтээлээс уран зургийн хүчтэй хэллэг болон хүн, байгалийн уялдаа холбоо, заримдаа хэний ч ойлгож мэдэхгүй ертөнц мэдрэгдэх аж. Түүний зургууд бүхэлдээ дүрслэлийн амьд шинж, үйл хөдөлгөөнийг илэрхийлдэг бөгөөд дийлэнх зураг нь маш том хэмжээтэй.

Герман улсын Берлин хотын урлагийн их сургуулийг 2010 онд төгсөж, урлагийн мастер зэрэг хамгаалсан зураач Э.Отгонбаярын “Морьдын төвөгөөн”, “Диваажин” цуглуулгын нь

уран бүтээлүүд энэ өдрүүдэд Шангри-Ла Моллд байрлах Art space Mongolia үзэсгэлэнгийн танхимд гарч байна. Түүний уран бүтээлийг гурван хэсэгт хуваан үздэг. Харин гурав дахь үеийн энэхүү гайхалтай бүтээлүүд нь хүн болон амьтдыг өвөрмөц төрх, өнгөнөөс өнгөнд уусах хөдөлгөөнөөр илэрхийлэхийг зорьжээ.

Аливаа урлагийн бүтээлийн цаана заавал уран бүтээлчийнх нь үзэл бодол хийгээд өгүүлэх гэсэн санаа нуугдаж байдаг. Тиймдээ ч онгон тансаг, диваажин мэт түүний ертөнц аюулд өртөөд байна. Түүний

урлагийн бүтээлүүд одоо уйлж, бас гуныхарч байна. Учир нь түүний “Антарктика панорама” зургуудад Өмнөд туйлд устаж үгүй болох аюулд өртөөд буй 20 мянган оцон шувууг 300x900 см-ийн хэмжээтэй зурагт дүрсэлжээ. Бүтээлч ийм том хэмжээг сонгож авсан нь энэ ажлын сэдэв ямар ач холбогдолтойг илтгэхийг хүссэнийх.

“Байгаль дэлхий сүйдэж буй бодит байдлыг хараад сэтгэл эмзэглэдэг. Үүний илэрхийлэл бол миний шинэ уран бүтээл болох “Антарктика панорама” юм. Оцон шувууны хувь заяа маш их сэтгэл хөдөлгөөн. Энэ амьтнаас бид өөрсдийгөө олж харж болно. Бид тэдний төлөө ямар нэг зүйл хийх хэрэгтэй. “Антарктика панорама” их шүүмжлэлтэй бас гунигтай

бүтээл” гэж Э.Отгонбаяр тодорхойлсон.

Түүний өмнө зурж байсан амьтдын дүрслэлээс энэ удаагийн оцон шувууны дүрслэл нь зөөлөн, уран сайхны төлсөл нь тухайн амьтныг хүнтэй зүйрлэсэнтэй холбоотой аж. Цагаан өнгийн оцон шувуудын гэдсэн дээр туссан нарны шаргал туяа нь тэдэнд амьдрал хайрлаач гэсэн утга санааг ч агуулж байж болох юм. Бүтээлийн өнгө будаг, цас мөс, оцон шувуудтайгаа уйлан хайлж буй гэлтэй.

Түүний уран бүтээлийн нэр нь “ОТГО”. Тэрбээр өнөөгийн нийгэмд тулгараад байгаа чухал сэдвийг ийнхүү өвөрмөц дүрслэлээрээ хөндсөн нь байгаль дэлхийг хамгаалахын төлөө босгосон орчин үеийн хөшөө дурсгал гэж урлаг судлаачид, шүүмжлэгчид үздэг байна. [ЗГМ]

КИНО

Америкийн кино өдөрлөгөөр гарах үнэ төлбөргүй таван киноны тухай

Америкийн орчин үеийн баримтат болон бие даасан (инди) кино урлагийн бүтээлүүдийг Монголын кино сонирхогч, үзэгчдэд хүргэх зорилгоор АНУ-ын Элчин сайдын яам болон Монголын Урлагийн зөвлөл хамтран Америкийн кино өдөрлөгийг зохион байгуулах гэж байна. Энэ сарын 15-17-нд “Тэнгис” кино театр зохион байгуулах тус өдөрлөгийн хүрээнд 2014 оны нийт таван кино бүтээлийг үнэ төлбөргүй

гаргах юм. Ингээд киноны хуваарь болон дэлгэрэнгүй мэдээллийг хүлээн авна уу.

Найруулагч Сайнди Мклеодын уран бүтээл болох “Цаглашгүй үр” кино 77 минут үргэлжлэх бөгөөд энэ сарын 15-нд 19.00 цагт гарна. Дэлхий даяар үрийн банкууд сүйрч, үр тариа хомсдоноос өлсгөлөн газар авч, уур амьсгалын өөрчлөлтийн эрчимтэй нөлөө газар тариалан эрхлэгчдийг хаа сайгүй

нэрвэж байгаа тухай өгүүлэх юм.

Найруулагч Каролин Жонсоны мөн оны бүтээл “Америк сувилагч” кино энэ сарын 16-нд 19.00 цагт гарна. 78 минут үргэлжлэх энэхүү кинонд Америкийн нийгэмд тулгараад байгаа хүн амын хөгшрөлт, дайн, ядуурал, шорон зэрэг томоохон асуудлын тухай, эдгээр салбарт ажиллаж байгаа сувилагч нарын ажил, амьдралыг өгүүлнэ.

“Далд хүчирхийлэл” хэмээх

кино энэ сарын 16-нд 21.00 цагт үзэгчдийн хүртээл болно. Найруулагч Синтя Хилл энэхүү кино гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд үзэгчдийг уриалсан баримтат кино юм. Үл үзэгдэгч хаалганы цаана болдог гэр бүлийн хүчирхийллийг бид өөрсдөө чимээгүй өнгөрүүлж, хууль тогтоомжийн дагуу эдлэх эрхээ дутуу ойлгосноос болж энэ асуудлыг ардаа орхиж байна. Тиймээс киноны гол дүр Дианна шиг яаж гэр

бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчоос баатар болон гарч, цаашид нийгэм дэх гэр бүлийн хүчирхийллийг багасгах вэ? гэдэг асуултын хариулыг олоорой.

“Эх өгөгдлийн дүр төрх” кино нь интернет хувьсгалаас хойш гарсан энэхүү нээлт бидний амьдралыг хэзээ ч төсөөлж байгаагүйгээр өөрчлөх тухай өгүүлэх болно. Кино энэ сарын 17-нд 17.00 цагт гарна. Санди Смолан энэ киног найруулжээ.

“Том мөрөөдөл” кино нь шинжлэх ухаан, математик, компьютер, инженерийн салбарт амжилт гаргаж яваа долоон бүсгүйн хүсэл мөрөөдөл, тэдний өөрт тулгарсан бэрхшээлийг хэрхэн даван туулж байгаа тухай өгүүлнэ. Том мөрөөдөлдөө хөтлөгдөн яваа энэ эмэгтэйчүүд охид, эмэгтэйчүүдийн тухай ирээдүйн олон охидын замыг засаж явааг та бүхэн энэ сарын 17-нд 19.00 цагт үзээрэй. [ЗГМ]

ДАРАА ТӨЛБӨРТ ДУГААР ШИГ АШИГЛАХ БОЛОМЖТОЙ

ЗЭС КРЕДИТ КАРТ

Хорин жилийн өмнө дараа төлбөрт дугаарыг нийгмийн шалгарсан хэсэг барьдаг байв. Харин одоо бол дундаж амьдралтайд тооцогдох хэн ч дараа төлбөрт дугаар барьдаг. Тэгвэл яг үүн шиг банк санхүүгийн бүтээгдэхүүн бол банкны КРЕДИТ КАРТ юм.

Монголчууд гар утастай болсон цаг саяхан. Хөршийндөө орж утсаар ярьдаг, холбоо руу гүйж хөдөө, гадаа байгаа хамаатан садантайгаа сураг чимээ авалцдаг байсан бидэнд гарт багтах жижигхэн утсаараа холбоо барина гэдэг хэсэгтээ л гайхамшиг байлаа.

Харин одоо наян настай буурлаас найман настай хүүхэд хүртэл гар утастай болж, зарим нь төлбөрөө дараа нь, зарим нь урьдчиллаад төлчихдөг болж. Хэрэглэндээ тааруулаад 20,30, 50 мянга гээд багцын хэрэглэгч ч болжээ. Одоо энэ тогтолцоонд гайхах зүйл нэг ч алга.

Харин хорин жилийн өмнө дараа төлбөрт дугаарыг нийгмийн шалгарсан хэсэг барьдаг байв. Яагаад гэвэл үүрэн телефоныхон төлбөрөө төлөхгүй байх вий гэхээс бусад нь төлж дийлэхгүй байх вий гэхээс эмээдэг байв. Харин одоо бол дундаж амьдралтайд тооцогдох Доржоо Дулмаа ч дараа төлбөрт дугаар барьдаг. Тэд хэрэгцээгээ мэддэг, төлбөрөө ч хугацаандаа төлөөд нэгэнт сурчээ.

Тэгвэл яг үүн шиг банк санхүүгийн бүтээгдэхүүн бол банкны КРЕДИТ КАРТ юм. Нэг үгээр хэлбэл дараа төлбөрт дугаар л гэсэн үг.

Та гадаадын олон киноноос кредит картаараа хүссэнээ худалдан авч байгааг харж байснаас бидэн шиг мөнгө зээлээч гэж бусдаас гүйж байхыг нь сонссон уу?

Мэдээж үгүй. Яагаад гэвэл тэд ойр зуурын санхүүгийн хэрэгцээгээ кредит картаараа шийдчихдэг юм. Монголчуудын хувьд ч тун удахгүй кредит картаараа өдөр тутмын санхүүгийн хэрэгцээгээ шийддэг болно. Яг л дараа төлбөрт дугаар ашигладаг болсон шигээ...

Кредит картыг заавал баян хүн авдаггүй юм. Та ажил төрөлтэй, цалинтай, орлоготой бол карт таных. Эсвэл та банкинд тодорхой хэмжээний хадгаламжтай бол карт авахад асуудалгүй.



Та кредит картаараа хүссэн үедээ, хүссэн худалдан авалтаа хийж болно. Дараа нь та зээлсэн мөнгө, худалдан авсан бараа, үйлчилгээнийхээ үнийг картандаа буцаан хийх буюу банкинд эргүүлж төлөх учиртай.

Нэг үгээр хэлбэл картаа ашиглан худалдан авалт хийсэн зээлээ 45 хоногийн дотор 100% буцаан төлсөн тохиолдолд банк танаас нэг ч төгрөгийн хүү авахгүй.

Харин зээлсэн мөнгөө бөөнд нь төлж чадахгүй байгаа тохиолдолд ашигласан мөнгөн дүнгийнхээ хамгийн багадаа 10-20 хувийг заасан хугацаанд нь төлөх учиртай юм. Дараа төлбөрт дугаарын хэрэглэгчид хугацаандаа төлбөрөө төлөөгүй тохиолдолд дуудлага хийх, авах боломжгүй хаагддаг шиг та төлбөр төлөх хугацаагаа хэтрүүлчихвэл торгууль төлөх болно.

Энэ бол таны хүлэсэн үүрэг бас хариуцлага.

Түүнчлэн таны кредит карт ашиглах хугацаанд сарын орлого тань нэмэгдсэн бол анх авсан зээлийн эрхийн хэмжээгээ нэмэгдүүлэх боломжтойгоос гадна олон төрлийн хөнгөлөлт урамшуулал, аяллын даатгал гэх мэт нэмэлт үйлчилгээнийг авах боломжтой юм байна.

Нэг үгээр хэлбэл бидний олонхийн ойлгодог шиг кредит картыг заавал баян хүн эзэмшдэггүй. Яг л гар утасны дараа төлбөрт үйлчилгээг өдөр тутмын амьдралдаа ашигладаг шигээ, кредит картаараа өдөр тутмын амьдралынхаа санхүүгийн хэрэгцээг шийдвэрлэх боломж хүн бүрт байна.

Спорт

Х.Баттулгыг тавьж явуулсангүй



Өөр нэр дэвшигч гараагүй тул Х.Баттулга дахин сонгогдож, Токиогийн олимп хүртэл жүдочдыг удирдах болж байна.

Б.Ганбаяр / ЗГМ ©

МЖБХ жил бүр хоёр тэрбум гаруй төгрөг зарцуулдаг

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

Монголын жүдо бөхийн холбооны VI их хурал лхагва гарагт МҮОХ-ны байранд боллоо. Хурлаар 2013-2016 оны олимпийн мөчлөгт хийсэн ажлын тайлан, Хяналтын болон Удирдах зөвлөлийн сонгууль, ерөнхийлөгчийн сонгууль явуулах байв. Үүнээс хамгийн их анхаарал татаж байсан нь одоогийн ерөнхийлөгч Х.Баттулга үүрэгт ажлаа үргэлжлүүлэх үү, хэрэв ажлаа өгвөл орыг нь хэн залгах вэ гэдэг асуудал.

Х.Баттулга 2006 онд МЖБХ-ны ерөнхийлөгчөөр сонгогдсоноос хойш жүдочдын амжилт тогтмол дээшилсээр байгааг бид мэднэ. Тухайлбал, өнгөрсөн 10 жилийн хугацаанд жүдогийнхон гурван олимпоос нэг алт, хоёр мөнгө, нэг хүрэл, дэлхийн аварга шалгаруулах долоон тэмцээнээс гурван алт,

нэг мөнгө, таван хүрэл медаль авсан юм. Монголд жүдо хөгжиж эхэлснээс хойш 2006 он хүртэл манай тамирчид олимп, дэлхийгээс нийт долоон медаль авсантай харьцуулахад энэ нь том амжилт байсан нь мэдээж. Тиймдээ ч жүдогийн хамт олон ерөнхийлөгчөөсөө салах тун дургүй байлаа. Харин Баттулгын хувьд ажлаа өөр хүнд шилжүүлэх хүсэлтэйгээ нууцгүй илэрхийлж байв.

Хурлын өмнө олны таамгийг тандвал Х.Баттулга ажлаа өгч, холбооны тэргүүн дэд ерөнхийлөгч Д.Дорлигжав оронд нь ирж магадгүй гэсэн яриа сонсогдож байв. Харин хурал олны бодсоноос өөр зураглалаар явагдлаа. Ерөнхийлөгчийг сонгох санал хураалт болоход танхимаас гавьяат дасгалжуулагч Г.Пүрэв-Очир босож, одоогийн ерөнхийлөгчийг улираан ажиллуулах саналтай байгаагаа илэрхийлэв. Өөр нэр дэвшигч гараагүй тул Х.Баттулга дахин сонгогдож, Токиогийн олимп хүртэл жүдочдыг удирдах болж байна. Тэрбээр сонгогдсоныхоо дараа “Миний хувьд сонгууль ажлаа өгье гэж бодсон. Харин та бүхэн надад дахин энэ хариуцлагатай ажлыг оноож байна. 2020 он хүртэл чадлаараа

тусалж дэмжээрэй” гэсэн юм.

Одоо Х.Баттулга ерөнхий нарийн бичгийн дарга томилох учиртай. Өдгөө энэ ажлыг хашиж буй М.Бөхбат улиран сонгогдох магадлалтай гэдэг нь бараг үнэн байх. Харин Хөдөлмөрийн баатар, гавьяат дасгалжуулагч, Үндэсний шигшээ багийн албаны дарга Ч.Насантогтох түүнийг

Олимпийн багийг сонгохдоо алдаа гаргасныг шүүмжилж байлаа

шүүгчийнхээ шугамаар гадагшаа тэмцээнд явах нь их байна. Үүнээс болж дотоод ажил цалгардах талтай гээд аль алиныг нь амжуулж ажиллахыг сануулсан юм. Мөн тэрбээр олимпийн багаа сонгохдоо алдаа гаргасныг шүүмжилж байлаа.

Их хурлын эхэнд генсек М.Бөхбат дөрвөн жилийн тайлангаа танилцуулсан нь анхаарал татсан. Тайлангаас харахад холбоо жил бүр хоёр тэрбум гаруй төгрөгийн орлого

олж, төдий хэрийг зарцуулдаг аж. Зөвхөн 2015 оноор жишээ авъя. Өнгөрсөн жил хоёр тэрбум, 821 сая төгрөгийн орлого олсон байна. Үүний 1.15 тэрбумыг улсын төсвөөс, 899 саяг холбооны ерөнхийлөгч гаргасан бол гранпри тэмцээний хураамжаас 287, хамтарсан бэлтгэлээс 100 саяг олж, үлдсэнийг нь бусад эх үүсвэрээс бүрдүүлжээ. Харин зарлагын тухайд гадаадын тэмцээн, бэлтгэл, сургалт семинарт хамгийн их буюу 1.3 тэрбумыг зарцуулжээ. Мөн “Чингис хаан” гранпри тэмцээн зохион байгуулахад нэг тэрбумыг зарцуулсан байна.

Гаргасан амжилт, авсан медаль ч жил бүр тогтвортой байж. Тухайлбал, 2013 онд ДАШТ, Мастерс, Их дуулга, гранпри, тивийн аваргын тэмцээнээс нийт 88 медаль (20 алт, 29 мөнгө, 39 хүрэл) авчээ. Харин 2014 онд 65 медаль (16-17-32), 2015 онд 79 медаль (19-21-39) өөрийн болгосон байна. Энэ жилийн хувьд одоогоор 20 алт, 25 мөнгө, 36 хүрэл, нийт 81 медаль аваад байгаа юм. Энэ жилийн тэмцээн дуусаагүй болохоор цаашид медалийн тоо нэмэгдэх боломжтой.

Зохион байгуулсан тэмцээнүүдийг тоогоор улсаа толгой

цохидог холбоо бол жүдо. Өнгөрсөн жил л гэхэд нийслэл хот болоод орон нутагт нийт 67 тэмцээн зохион байгуулж, үүнд нь давхардсан тоогоор 20770 тамирчин хамрагджээ. Энэ жилийн хувьд 79 тэмцээн хийхэд нийт 24490 тамирчин өрсөлдсөн байна.

Өнгөрсөн дөрвөн жилийн мөчлөгт хамгийн үлгэр жишээ ажилласан холбоо бол МЖБХ. Гаргасан амжилт ч үүнийг нотолно. Гэвч олимпийн наадамд л санаснаас тааруу барилдаж, нэг хүрэл медальтай ирсэн билээ. Тэгвэл холбоо одоогийн бүрэлдэхүүнээ хадгалан үлдэж, Токиогийн олимпийн төлөө дахин нэг дайралт хийхээр болсон нь энэ. Тэдний хувьд олон ажил төлөвлөснөөс жүдогийн ордон барих төсөл хамгийн том нь байх болов уу. Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг буюу Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн ард барих тус ордны зураг төслийн ажил хийгдэж, цэвэр, бохирын хоолой, цахилгаан, дулааны шугамын асуудлыг шийдвэрлэхэд бэлэн болоод буй. Ордныг барихад шаардлагатай хөрөнгийг хандиваар цуглуулахаар аян өрнүүлээд байгаа билээ. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» **ОЛИМПИЗМ**
“Рио-2016” паралимпийн наадмаас пауэрлифтингийн ОУХМ Э.Содномпилжээ хүрэл медаль хүртлээ. Хоёр хүрэл медальтай болсон монголчууд багийн дүнгээр 67 дугаарт бичигдэж байна. Одоогоор 161 орноос 78 нь медаль аваад байгаа юм.

Лондоны олимпоос хүндийг өргөлтийн төрлөөр хүрэл медаль хүртсэн Молдавын А.Кырыку допинг хэрэглэж байсан нь тогтоогджээ. Тиймээс олимпийн хүрэл медалийг нь хураахаар болсон байна. Өмнө нь Оросын жад шидэлтийн тамирчин М.Абакумова мөн дээрх шалтгаанаар Бээжингийн олимпийн мөнгөн медалиа хураалгахаар болсон юм.

» **ХОККЕЙ**
“Баффало”-гийн довтлогч Райан О’Райли Дэлхийн цомд оролцох Канадын шигшээд дуудагдлаа. Тэрбээр гэмтэл авсан Т.Сегинийг орлох юм. О’Райли өнгөрсөн улиралд 71 тоглолтод оролцохдоо 60 оноо авчээ.

Дэлхийн цомын бэлтгэлээ базааж буй Америкийн шигшээ Финландтай нөхөрсөг тоглолт хийлээ. Америкчууд энэ тоглолтод өрсөлдөгчөө 3:2-оор хожсон байна. Финланд 3:0-ээр хожигдож яваад хоёр шайб хийсэн ч тоог тэнцүүлж чадсангүй.

» **АВТО СПОРТ**
“Формула 1”-ийн эзэн Б.Экклстоун дэлхийн дөрвөн удаагийн аварга А.Простыг бүх цаг үеийн шилдэг нисэгч гэж бодож явдгаа өгүүллээ. Цагтаа “Макларен”, “Феррари”, “Рена”, “Уильямс” багт уралдаж явсан тэрбээр 1985, 1989, 1989, 1993 онд дэлхийн аварга болсноос гадна дөрвөн удаа аман хүзүүдэж байв.

» **ТЕННИС**
Оросын теннисчин Т.Габашвили Польшид болж буй олон улсын тэмцээний хоёрдугаар тойрогт шалгарч чадсангүй. Тэрбээр дэлхийн чансааны 262-т бичигддэг Чехийн З.Коларуд 1:6, 6:3, 3:6-гаар ялагджээ.

» **ХӨЛБӨМБӨГ**
“Лестер”-ийн довтлогч Д.Дринкуотер өөрийн багийг “Ноттингем Форест”-ын амжилтыг давтан Аваргуудын лигт түрүүлж магадгүй хэмээн ярьжээ. “Ноттингем Форест” 1979 онд энэ тэмцээнд анх ороод түрүүлсэн түүхтэй. “Лестер”-ийн хувьд өнгөрсөн улиралд Английн аварга болж, энэ жил Аваргуудын лигт дебют тоглолтоо хийхээр болов.

Аваргуудын лигийн нээлтийн тоглолтод “Барселона” Шотландын “Селтик”-ийг 7:0-ээр хожлоо. Энэ тоглолтод Л.Месси гурван гоол оруулж, гол баатраар тодров. Аргентин эрийн хувьд тус тэмцээнд зургаан удаа хет-трик хийсэн анхны хөлбөмбөгч болжээ.

» **САГСАН БӨМБӨГ**
Азийн оюутны аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн энэ сарын 19-24-нд Улаанбаатар хотноо болох гэж байна. Тэмцээний сугалаа лхагва гарагт явагдахад манайхан Тайвань, Казахстан, Макаогийн багтай хамт “В” хэсэгт оржээ. Нөгөө хэсэгт БНХАУ, Хонконг, БНСУ-ын баг өрсөлдөх юм.

“Оклахома”-гийн довтлогч М.Макгэри хар тамхи хэрэглэсний улмаас 15 тоглолтод оролцох эрхээ хасууллаа. Өмнө нь лигийн удирдлагууд түүнийг 10 тоглолтоор торгоод байсан ч шийтгэлээ чангаруулсан байна. Түүний шийтгэл шинэ улирлын эхнээс хэрэгжиж эхэлнэ.

ШАТАР

Эмэгтэйчүүд сүүлийн тойрогт тэнцсэн бол...

Б.Энхжин
ЗГМ

Азербайжаны Бакуд болсон дэлхийн шатрын олимпиад Монголын тамирчдын хувьд амжилттай өндөрлөж байна. Дэлхийн 180 орны шилдэг шатарчид оюун ухаанаа уралдуулахад манай бүсгүйчүүд 20, эрчүүд 51 дүгээр байр эзэлсэн юм. Нөгөө ТОП хэдэн төрөлтийгөө харьцуулахад энэ байр чамлалттай санагдаж магадгүй. Гэхдээ урьд өмнөх олимпиадуудад орсон байдлыг бодолцвол энэ нь дэвшил байв.

Эмэгтэй багийн тухайд 11 өрөг тоглохдоо зургаа хожиж, хоёр тэнцэн, гурван удаа хожигдсон юм. Ингэхдээ Финланд, Ямайк, Тажикистан, Монтенегро, Казахстан, Филиппинийг хожиж, Герман, Америктай тэнцэн Азербайжан, Чех, Израилийн багт ялагдсан юм. Хэрэв сүүлийн тойрогт Израильтай тэнцсэн бол эхний 10-т ч орох боломжтой байлаа. Эмэгтэй шатарчид 1980-аад оны үед олимпиадад 16 дугаар байр эзэлсэн нь дээд амжилт. Энэ удаа дээд амжилтаа ахиулах бүрэн боломжтой байсан ч бага зэрэг аз дутсан юм. Түүнчлэн манайхан өнөө цагийн шилдэг эмэгтэй шатарчин Б.Мөнгөнтуулгүйгээр оролцоод ийм амжилт үзүүлснийг бодолцох ёстой. Эмэгтэй багийнхнаас их мастер А.Энхтуул хамгийн сайн тоглолоо. Дөрөвдүгээр ширээнд нүүсэн тэрбээр 10 өргөөс зургаа



mongolchess.mn ©

хожиж, гурав тэнцэн, нэг удаа хожигдсон юм. Ингэснээр рейтингээ 14 оноогоор ахиулах боломжтой болжээ. Дэлхийн хэмжээний том тэмцээнд рейтингээ ингэж ахиулна гэдэг яах аргагүй мундаг үзүүлэлт. Түүнчлэн олон улсын мастер У.Лхамсүрэн тавдугаар ширээнд нийлбэр дүнгээр 11 дүгээр байрт орсон. Тэрбээр найман өрөг тоглохдоо дөрөв хожиж, хоёр тэнцэн, хоёр удаа дийлдсэн юм.

Эмэгтэйчүүдийн тэмцээнд Хятадын баг 20 оноогоор хол тасархай гэргүүлж, Польш, Украин удаалав. Орос, Энэтхэгийн хүчтэй баг дөрөв, тавдугаар байр эзэлсэн. Харин манайхтай эвийн гэрээ байгуулсан америкчууд зургаад бичигдсэн юм. Хятадын хувьд Вьетнам, Румынтэй тэнцэж, бусад есөн өрсөлдөгчөө буулгаж авлаа. Сүүлийн тойрогт оросууд тэднийг хожсон бол алтан медаль

хүртэх боломжтой байв. Гэсэн ч нанхиад шатарчид шийдвэрлэх тулаанд 2:1-ээр илүүрхэж, ноднин ард нь орсон хариугаа авсан юм.

Манай эрэгтэй багийн тухайд 11 тоглолтынхоо зургаад хожиж, нэг тэнцэн, дөрвөн удаа ялагдлын гашууныг амсчээ. Манайхан гараагаа сайхан эхэлж, гурван хожиж, нэг тэнцээтэйгээр 13 дугаар байрт хүртэл бичигдэж байсан. Гэхдээ үүнээс хойш

уруудсаар 51 дээр тогтов. Чансаагаараа 57-д бичигдсэн баг зургаан байр урагшилсан нь энэ. Монголын багаас их мастер Ц.Батчулуун хамгийн сайн тоглож, 7.0 оноогоор дөрөвдүгээр ширээнд 18 дугаар байрт орсон юм. Тэрбээр 10 тоглохдоо тав хожиж, дөрөв тэнцэн, нэг удаа хожигджээ. Ираны их мастер Л.Шахин л манай хүнийг хожсон ганц хүн байв. Батчулуун олимпиадад сайн тоглосноор рейтингээ 13-аар ахиуллаа.

А.Энхтуул 10 өргөөс 7.5 оноо авч, рейтингээ 14 оноогоор ахиулав

Эрчүүдийн тэмцэлд АНУ, Украин ижил 20 оноогоор тэнцсэн ч коэффициентийн илүүгээр Америкийн баг тэргүүлэв. Энэ хоёр баг зургадугаар тойрогт хоорондоо таарахад америкчууд 2:1-ээр илүүрхсэн юм. Хүрэл медалийг Оросын баг хүртжээ. Оросын хувьд дөрөвдүгээр тойрогт Украинд ялагдсан нь байр ахих боломгийг үгүй хийсэн. Харин ноднингийн аварга Хятад дөнгөж 13-т оржээ.

Дараагийн буюу 43 дахь удаагийн олимпиад хоёр жилийн дараа Гүржийн Батуми хотноо болно. [ЗГМ]

Лавлах

ҮЙЛЧИЛГЭЭ Элэг, бөөрний үзлэг үнэгүй хийнэ

Б.Баярмаа
ЗГМ

“Эрүүл элэг” хөтөлбөрийн хүрээнд “Халпи Веритас” оношлогооны төв сарын аян зарлалаа. Есдүгээр сарын 15-наас нэг сарын хугацаанд элэгний үнэ төлбөргүй үзлэг хийх аж. Мөн элэгний В, С вирусын эмчилгээ нэн шаардлагатай зарим иргэдийг төлбөргүй эмчлэхээр болжээ. Аянд хамрагдах хүсэлтэй иргэдийг өнөөдрөөс эхлэн бүртгэнэ.

Түүнчлэн “Улаанбаатар Мед” эмнэлгээс бөөрний дутагдлаас урьдчилсан сэргийлэх зорилгоор бөөрний үзлэг, шинжилгээг үнэгүй хийж байна. Есдүгээр сарын 16-ныг хүртэл хөнгөлөлттэй үйлчилгээ үргэлжлэх юм. [ЗГМ]

КИНО Баримтат киноны өдөрлөг болно

АНУ-ын ЭСЯ-наас есдүгээр сарын 15-17-нд “Америкийн кино өдөрлөг 2016” хөтөлбөрийг зохион байгуулж байна. Өдөрлөгийн хүрээнд “Тэнгис” кино театрт “Цаглашгүй үр”, “Америк сувилалч”, “Эх өгөгдлийн дүр төрх”, “Том мөрөөдөл” зэрэг таван бүтээл гарах аж. Эдгээр бүтээл нь нийгэмд тулгамдсан асуудлуудыг тусгасан баримтат кино юм.

Тухайлбал, есдүгээр сарын 16-ны баасан гарагт 21.00 цагаас гарах “Далд хүчирхийлэл” кино нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн түүхийг харуулжээ.

Мөн кино өдөрлөгийн хүрээнд АНУ-аас туршлагатай кино найруулагчдыг урьж, сургалт зохион байгуулж байна. [ЗГМ]

ТЕХНОЛОГИ Шинэ ээжүүдийн “туслах”

Жирэмсэн эмэгтэйчүүд, шинэхэн ээжүүдэд зориулсан “Ээж” нэртэй гар утасны аппликэйшн шинэчлэгджээ. Уг аппликэйшнээс ургын өсөлт хөгжил, эрүүл хооллолт, нярайн арчилгаа, дасгал хөдөлгөөн, эхийн биед орох өөрчлөлт зэрэг 1200 гаруй зөвлөгөөг унших боломжтой. Мөн жирэмсний хугацаагаа бүртгүүлснээр төрөх хүртэлх 41 долоо хоногийн турш яг танд хэрэгтэй санамжууд гар утсанд тань очих болно.

“Ээж” аппликэйшн нь өрхийн эмнэлэгт очих цагийг хэмнэхээс гадна бусад шинэхэн ээжүүдтэй санал бодлоо солилцох боломжтой юм байна. Уг аппликэйшнийг <http://www.eej.mn> сайтаас татах боломжтой аж. [ЗГМ]

ЗӨВЛӨГӨӨ Төмсийг жигнэж хэрэглээрэй

Хүнсний ногоог, ялангуяа төмсийг хальстай нь чанаж хэрэглэвэл илүү тэжээлтэй байдгийг мэдэх үү. Төмсийг хэрчиж чанавал 30-50 хувийн, хальсийг нь арилгаж бүтнээр нь чанавал 60-70 хувийн, хальстай нь чанавал 75 хувийн амин дэмийн агууламжтай байдаг аж. Гэхдээ чанахаас илүү хальстай нь жигнэж идэхийг зөвлөж байна. Ингэвэл тэжээллэг чанараа алддаггүй. Хэрэв төмсний шороо амархан арилахгүй байвал хүйтэн усанд угаахыг зөвлөж байна.

Төмс нь бөөрөнхий байцаа, шар луувангаас хоёр дахин илчлэг ихтэй байдаг аж. Мөн цусны даралт бууруулах, ходоодны шарх, гэдэсний түгжрэл, түлэгдсэн арьсыг эмчлэхэд өргөн хэрэглэдэг. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

08.00	MNB 08.30 “NHK үзүүлж байна: Газар хөдлөлт”	Bloomberg 07.00 “Хөгжилд хүрсэн түүх” нэвтрүүлэг	Боловсрол 09.00 “Cook Club” хоолны шоу нэвтрүүлэг	Монгол ТВ 09.30 “Тог тог тог” хүүхдийн нэвтрүүлэг
12.00	11.20 “Нутгийн аялгуу”	11.30 “Байршил” нэвтрүүлэг	12.10 “Найзууд” ОАК 129, 130 дугаар анги	12.00 “Хөтөч” мэдээллийн хөтөлбөр
14.00	14.10 “Сэтгэлийн есөн цацал” МУГЖ Б.Сарантуяа	17.00 “The Pulse” шууд орчуулгын хөтөлбөр	16.45 “Аугаа уран зургууд” нэвтрүүлэг	15.30 “Пинокио” ОАК 9 дугаар анги
18.00	17.05 “Энд гарц байна: Оюутнууд зөв хооллодог уу?”	18.00 “Бизнесийн төв цэг”	18.30 “Score news” мэдээллийн хөтөлбөр	18.00 “Наашаа цаашаа”
20.00	20.00 “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр	20.45 “Цахим засаглал I” нэвтрүүлэг	21.00 “Ялалт” шоу нэвтрүүлэг	20.00 “Оргил цаг” мэдээллийн хөтөлбөр
22.00	22.05 Монгол хэл ба нийгмийн шаардлага: Албан бичгийн хэл найруулга	22.00 “Эзэнт гүрнийг богсосон нь” нэвтрүүлэг	22.00 “Гал тогоо” ОАК 6-р бүлэг 17, 18 дугаар анги	22.20 “Декстер” ОАК /season 8/ 7 дугаар анги

ОНЦЛОХ ҮЗВЭР 10000 төгрөгөөр хязгааргүй тоглох эрх



Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн 50 жилийн ой удахгүй тохионо. Энэ ойг угтан тус хүрээлэнд есдүгээр сарын 16-19-нд 10000 төгрөгөөр бүтэн өдрийн турш бүх тоглоомоор хязгааргүй тоглох боломж олгож байна. Энэ хөнгөлөлт нь 11.00-23.00 цагийн хооронд үйлчлэх аж. Үндэсний соёл амралтын хүрээлэнд есдүгээр сарын 16-нд реппер Gee, дуучин Наагий нар тоглолт хийнэ. Харин 18-нд “Мотив” хамтлагийн дуунуудыг сонсоорой. Мөн өдөр бүр багачуудад зориулсан Бонго ба түүний найзуудын үзүүлбэр болон үндэсний дуу бүжгийн “Түмэн-Эх” чуулгын тоглолтыг үзэх боломжтой. [ЗГМ]

ҮЗВЭР

УЛААНБААТАР ЧУУЛГА

“Нарны хүүхдүүд” төвийн авъяаслаг багачуудын тоглолт есдүгээр сарын 17-нд болно. Тус төвийг 2003 онд Сонгинохайрхан дүүргийн Улаанчулуутын орчимд амьдардаг хүүхдүүдэд зориулан нээсэн юм. Таван хүүхдийн бүрэлдэхүүнтэй “Нарны хүүхдүүд” хамтлаг 2003 оноос хойш Япон улсад 15 удаа ардын урлагийн тоглолт хийжээ.

BLUE SKY HOTEL&TOWER

Монгол-Японы хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг энэ сарын 23-нд 15.00-19.00, 24-нд 12.00-17.00 цагт болно.

СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨ

“Маск” продакшны “Эх орон инээмсэглэж байна” шоу тоглолт өдөр бүр 19.00 цагаас болж байна. Тасалбарын үнэ 12000 төгрөг.

SS CLUB

Олон улсын чанартай анхны төрөлжсөн металл хөгжмийн наадам “Noise metal fest 2016” арга хэмжээ энэ сарын 23-24-нд болно. “Noise metal fest 2016” наадмын хүрээнд дэлхийд танигдсан Японы Sete star sept болон Desecravity, ОХУ-ын Inner Missing, АНУ-ын Hitobashira зэрэг амьд хөгжмийн хамтлаг оролцоно.

УЛСЫН ДУУРЬ БҮЖГИЙН ЭРДМИЙН ТЕАТР

Улсын Филармонийн Морин хуурын чуулгын уран бүтээлчид Гуанжоу хотын соёл урлагийн төвийн уран бүтээлчидтэй хамтарсан концертоо энэ сарын 22-нд тоглох гэж байна.

МОНГОЛ-ЯПОНЫ СОЁЛЫН ТӨВ

Сайн дурын үйл ажиллагаанд оролцох хүсэлтэй залууст чиглэсэн “I Volunteer, Do you?” нээлттэй өдөрлөг есдүгээр сарын 17-ны 12.00 цагт Монгол-Японы соёлын төвд болно. Энд ирснээр сайн дурын ажилтан хэрэгтэй байгууллага, төсөл хөтөлбөрүүдтэй холбогдох боломжтой.

ЧИНГИСГИЙН ТАЛБАЙ

Бүх нийтийн гүйлт аравдугаар сарын 8-нд болно. Чингисийн талбайгаас эхлэх гүйлтийг Нийслэлийн Биеийн тамир, спортын хорооноос зохион байгуулна.

ЗУРХАЙ



Билгийн тооллын 14
Намрын дунд улаагчин тахиа сарын нэг цагаан мэнгэтэй цагаан хулгана өдөр
Үс засуулбал: Эд мал арвижна
Наран ургах, шингэх: 06.35-19.07
Барилдлага: Үл тохирох
Шүтэн барилдлага: Өглөх үхэхүй

Ардын тооллын есдүгээр сарын 15, Бархасвадь гараг. Билгийн тооллын 14, Чөдөр одтой. цагаан хулгана өдөр.

Өдрийн наран 6 цаг 35 минутад мандаж, 19 цаг 07 минутад жаргана. Тухайн өдөр бич жилтнээ аливаа жилийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улааны үйл, төлөг тавих, морь уралдахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогдод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.


ГАЛТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

Москва-УБ	23.45	07.50
УБ-Эрээн	21.00	11.25
УБ-Бээжин	08.30	11.40
Эрхүү-УБ	16.32	06.53
УБ-Эрхүү	20.45	02.15
УБ-Дархан	10.10	14.10
Дархан-УБ	14.45	19.10
УБ-Замын-Үүд	17.30	07.40
Замын-Үүд-УБ	18.15	08.55

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Токио	08.55	13.40
Токио-УБ	14.40	20.10
УБ-Бээжин	07.10	08.25
Бээжин-УБ	09.30	13.00
УБ-Москва	10.15	10.55
Москва-УБ	19.40	20.50
Москва-Берлин	11.55	13.35
Берлин-Москва	14.55	18.25

ҮГИЙН СҮЛЖЭЭ



- Мал муулах, цагаан идээ болон эд гаргахаас цээрлэдэг өдөр
- Гавьяат малчин, тод манлай уяачийн хүү улсын начин
- Цонхны гадна талын тавцан

ТАШУУГААР:

- Нобелийн шагнал хүртсэн анхны монгол эрдэмтэн,

- Мал муулах, цагаан идээ болон эд гаргахаас цээрлэдэг өдөр
- Гавьяат малчин, тод манлай уяачийн хүү улсын начин
- Цонхны гадна талын тавцан
- Нийслэлээс хойд зүгт орших зуслан байрлах нэгэн ам
- Төв аймгийн сум

Өмнөх дугаарын хариу /09.14




БОСООГООР:

- Адууны ховор сайхан явдал
- Ховд аймгийн сум
- Тооны нэр
- Хөгжмийн үндсэн долоон нотны нэг
- Зуун мянга
- Хүндлэн дуудах үг


- Төрийн шагналт зохиолч
 - Химийн элемент
- Хөндлөнгөөр:**
- Толгойгоо тасдуулсан ч олон хоног амьдарч чаддаг орон байрны шавж
 - Жижиг мэргэч
 - Лац

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	IX.15	IX.16	IX.17	IX.18	IX.19
Уүлшинэ	20° / 6м/с 6° / 5м/с	17° / 8м/с 6° / 6м/с	14° / 8м/с 5° / 7м/с	14° / 7м/с 5° / 7м/с	16° / 7м/с 4° / 6м/с



ЗГМ: КОМИКС



[ЗГМ]

“ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ”
СОНИНЫ ОНЛАЙН ЗАХИАЛГА
ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

“ZGM-FINANCIAL TIMES-NYT”
ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС
ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД
5000 ТӨГРӨГ

99903581, 70103131

УНШИГЧ ТА МАНАЙ
СОНИНЫ НИЙТЛЭЛ, МЭДЭЭ,
СУРВАЛЖЛАГАТАЙ
ХОЛБООТОЙ САНАЛ
ХҮСЭЛТЭЭ

OPED@ZASAG.CO

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

Байршил



Mongolian Property Management Group

Real Estate Service · Real Estate Appraiser · Real Estate Developer

Address: Sukhbaatar district, Naryn zam 56, Zamiin tsagdaa,
Tsoma Office, 601, Ulaanbaatar, Mongolia
Phone: +976 8806 8207, +976 8800 3620
www.mpmgroup.mn



Санхүүгийн хөгжилд хамтдаа



RIVER GARDEN
Хэмжээ: 179,8 м2
Өрөө: /4 унтлагын өрөө/
Граж: 2 машины зогсоол
Үнэ: 3,900,000 ₮ /худалдана/
Хаяг: ХУД, Маршалын гүүр



JAPAN TOWN, C4 APARTMENT
Хэмжээ: 138.52 мкв талбайтай
Граж: 1 машины зогсоолтой
Өрөө: 3 өрөө байр түрээслэнэ
Үнэ: 2400\$
Хаяг: ХУД



BELLA VISTA
Хэмжээ: 160 м2
Өрөө: 3 /1 давхарт/
Граж: 2 машины зогсоолтой
Үнэ: 2200 \$ /түрээслүүлнэ/
Хаяг: ХУД, Зайсан



GALAXY TOWER
Хэмжээ: 737 м2
Өрөө:
Граж: 40 машины зогсоол
Үнэ: 2550\$/худалдана/
Хаяг: ХУД

EASTERN PLAZA
Хэмжээ: 150-300 м2
Зориулалт: Оффис үйлчилгээ
Граж: Машины зогсоолтой
Үнэ: Зах зээлийн үнээр түрээслүүлэх болон худалдана
Хаяг: Хотын А зэрэглэлийн бүс болох СБД, Сөүлийн гудамж, NARAN Mall их дэлгүүрийн чанх хойно.
Утас: 98995225, 90112555



ОДДЫН ХОТХОН
Хэмжээ: 119 м2
Өрөө: 4
Граж: 2 /20 м2/
Үнэ: 2,500,000 ₮ /түрээс/
Хаяг: ХУД



ЗАЙСАНГИЙН ОРГИЛ
Хэмжээ: 136,06 м2
Өрөө: 5 өрөө байрыг гадаадын иргэнд яаралтай түрээслүүлнэ.
Үнэ: 2000\$
Хаяг: ХУД



ОФФИС
Хэмжээ: 75м2
оффис үйлчилгээний зориулалттай талбайг зах зээлийн үнээс хямдаар түрээслүүлнэ.
Үнэ: 30,000 ₮ /м2/
Хаяг: СБД, Хотын төвд



BUDDHA VISTA
Хэмжээ:
Өрөө: 4 /5 давхарт/
Граж:
Үнэ: 2300 \$ /түрээслүүлнэ/
Хаяг: ХУД, Зайсан



НҮХТ
Хэмжээ: 900 м2 /газар/
Хэмжээ: 250 м2 /зуслангийн байшин/
Граж: 3 машины зогсоол
Үнэ: 500,000,000 ₮



BRAUNHAUS
Хэмжээ: 100 м2
Өрөө: /2 унтлагын өрөө/
Граж:
Үнэ: 200,000 \$ /худалдана/
Хаяг: Сөүлийн гудамж

ROMANA RESIDENCE
Хэмжээ: Цоо шинэ 66мкв талбайтай
Өрөө: 2 өрөө байр түрээслүүлнэ
Үнэ: 1000\$
Хаяг: ХУД



REGENCY RESIDENCE
Хэмжээ: 165 м2
Өрөө: /3 унтлагын өрөө/
Граж: машины зогсоолтой
Үнэ: 335,000 \$ /худалдана/
Хаяг: БЗД, 13 дугаар хороо



BLUE SKY
Хэмжээ: 118 м2
Өрөө: 3
Граж:
Үнэ: 1,500,000 ₮ /түрээслүүлнэ/
Хаяг: ХУД, Зайсан



RE/MAX Mongolia

Танд зориулсан үл хөдлөх хөрөнгийг эндээс...

Хаяг: Баянзүрх дүүрэг, 26 хороо Их хүрээ гудамж,
Парк сайд төвийн 3 давхарт
Утас: 77073399, 94093390, 94043390
<http://www.remax.mn>



SEOUL PLAZA
А зэрэглэлд байршилтай, нийт 11 давхар, 8800 м2 талбайтай, 1-4 давхарт: Өндөр зэрэглэлийн худалдаа, үйлчилгээний төв 5-9 давхарт: Оффис 10-11 давхарт: Ресторан, лоунж 2016 оны зургадугаар сард бүрэн ашиглалтанд орно.
Хаяг: БГД, "Сөүл плаза" бизнес төв



MD CENTER
Хэмжээ: 2380 м2
Өрөө: 3 давхар, 2 жигүүр
Граж: 30-40 машины ил зогсоол 20 машины дулаан граж
Үнэ: 2,500,000 ₮ /худалдана/
Хаяг: ХУД, 15-р хороо



ЦЭЛМЭГ ТӨВ
Хэмжээ: 9 давхар оффис
Өрөө: тус бүр 624 м2
Граж: ил зогсоол
Үнэ: 60,000-70,000 ₮ /түрээслэнэ/
2200-2900 \$/худалдана/
Хаяг: СБД, 1-р хороо



9 ЭРДЭНЭ
Хэмжээ: 642 айлын орон сууц
Өрөө: 2-3
Граж:
Үнэ:
Хаяг: БГД 3-р хороо



ПАРКСАЙД РЕЗИДЕНС
Хэмжээ: 52.58- 178.47 м2
Өрөө: 2-5
Граж:
Үнэ: 2,600,000-3,000,000 ₮
Хаяг: БЗД




RESIDENCE 60
Хэмжээ:
Өрөө: 1-5
Граж: дулаан зогсоол
Үнэ: 1750-2650 \$
Хаяг: БЗД, 4-р хороо



ИХ МОНГОЛ РЕЗИДЕНС
Хэмжээ: 195 айлын
Өрөө: 3-4 /сонголт/
Граж: Газар доорх байгууламж бүхий 165 граж
Хаяг: БЗД



BLUE GEM-4
Хэмжээ: 15 давхар
Өрөө: Сонголттой
Граж: байгаа
Үнэ: 2,800,000-3,200,000 ₮
Хаяг: БГД, UB Place-ын хажууд



ЗАЙСАН ГОЛДЕН ВИЛЛ
Хэмжээ: 100 айлын орон сууц
Өрөө: 3-5 /сонголттой/
Граж: 150 автомашины зогсоол
Үнэ: 3,500,000-3,800,000 ₮
Хаяг: ХУД, 11-р хороо



NARAN PLACE
Хэмжээ: 120 айлын тохилог сууц
Өрөө: 2-5 /сонголттой/
Граж: давхар зогсоол /төлөвлөсөн/
Үнэ:
Хаяг: БЗД, 6-р хороо

Шинэ Ерөнхийлөгч, хуучин арга барил

Узбекистаны засгийн эрхийг атгагчид Каримовын залгамжлагчаар ганц хүнийг зааж байгаа нь ноён Мирзиёев. > 10

Олимпын тамирчдын мэдээлэл хулгайлсан хэрэгт оросууд буруутай

Fancy Bears бүлэг хэд хэдэн улсын шигшээ багтай холбоотой баримт материал дэлгэхээр сүрдүүлж байна. > 10

Өндгөн эсгүйгээр амьдрал үүсгэнэ

Эрдэмтдийн судалгаа эмбриологийн шинжлэх ухаанд хоёр зуун жил тогтнож ирсэн ойлголтыг нураав. > 10

Баяртай давхацсан хөл хорио

Эми Казмин

Энэтхэгийн Кашмир мужид жагсаал цуглааныг намжаахын тулд Шинэ Дели исламын сүмүүдийг хааж, интернетийг түр зогсоох шийдвэр гаргасанд нутгийн мусульманууд ихэд эгдүүцжээ. Уг арга хэмжээ Исламын хуанлийн хамгийн ариун баяруудын нэг болох Эйд ёслолыг тэмдэглэх ажиллагааг үнэн хэрэгтээ хориглосон явдал болов. Энэ зуны туршид Кашмирийн хөндийд үргэлжилсэн Засгийн газрыг эсэргүүцсэн жагсаал, мөргөлдөөний улмаас наяд орчим хүн алагдаж, хэдэн мянган иргэн шархаджээ.

Гималайн нуруунд оршдог голдуу мусульман хүн амтай энэ бүсэд албан ёсоор хөл хорих цаг тогтоосон. Тэрчлэн нийслэл Шринагар хотын исламын хоёр том сүмд олон нийтийн мөргөл үйлдэхийг хориглосон юм. Энэтхэгийн албаныхан утасны үйлчилгээ болон интернет сүлжээг 72 цаг зогсоох арга хэмжээ авчээ. Энэ нь шашны баярын үеэр жагсаал цуглаан зохион байгуулах, Шринагар дахь НҮБ-ын ажиглагчдын байр руу халдан довтолхоос сэргийлэх зорилготой гэж мэдэгдсэн байна.

Шринагар гардаг Rising Kashmir сонины редактор Шужаат Бухари “Энэ бол Кашмирийн түүхэн дэх хамгийн хар өдөр. Анх удаа Эйд баяраар хөл хорилоо. Мусульмануудын хувьд заавал үйлдэх ёстой сүмийн мөргөлийг явуулах нөхцөлийг хаасан явдал болов. Бид Эйдийн үеэр сүмүүдийг хааж байхыг хэзээ ч хараагүй. Үүнийг юугаар зөвтгөх юм бэ?” гэжээ. 2010 онд Кашмирийн мусульманууд цэрэг, цагдаагийн хүчинтэй мөргөлдөөний улмаас 110 хүн алагдаж байв. Тэр үеэс



BMM©

хойш энэ зун хамгийн их цус урсгасан тэмцэл өрнөсөөр Эйд баярын өдрүүд ойртлоо.

Энэхүү зөрчилтэй байдал Ерөнхий сайд Нарендра Модийн Засгийн газарт ихээхэн бэрхшээл үүсгэжээ. Пакистаны талаас салан тусгаарлах үзэл босогчдыг илт дэмжих нь суларсан. Гэвч сүсэгтний дуртай баяр цус урсах шалтгаан болж магадгүй юм. Сүүлийн жилүүдэд Кашмирт зэвсэгт босогчид болон халдлагын тоо цөөрсөн. Гэсэн хэдий ч Шинэ Дели 44 мянган хүний амийг авч

одсон ужи зөрчлийг зохицуулах шийдтэй алхам хийлгүй өдийг хүрээд байна. Кашмир дэлхийд хамгийн их цэрэгжсэн бүсийн нэгд тооцогддог агаад аюулаас хамгаалах хүчний хатуу хяналт нутгийн иргэдийн гомдлыг сэдэрж, сөргөлдөөнийг өдөөдөг гэж үзэх нь бий.

Кашмирийн асуудлаар шинжээчид ярихдаа Модийн тэргүүлдэг Бхаратия Жаната нам сүүлийн хоёр жилд хинди шүтлэгтний дээд кастыг бусдаас дээгүүр тавих хандлага гаргасан юм. Үүний улмаас нутгийнхны

сэтгэлд гүн шингэсэн Энэтхэгийг эсэргүүцэх үзэл асаж эхэлсэн гэж үздэгээ онцолсон байна. Хинди сүсэгтний ариун шүтээн болох үхрийн наймаа эрхэлдэг мусульманууд руу довтолсон хэрэг хэд хэдэн удаа гарчээ. Намдуу байсан зөрчил Кашмирийн залуу үеийнхний нийгмийн сүлжээгээр уриалан дуудагч Бурхан Вани гэгч долдугаар сард алагдсаны дараа дүрэлзэж эхлэв.

Гэвч Модийн засаг захиргаа Кашмирт өрнөсөн тэмцлийг Пакистанаар дэмжүүлсэн

хууль, дэг журмыг эсэргүүцсэн бослого мэтээр харуулахыг хичээв. Исламабад Кашмирийн салан тусгаарлагчдыг сургаж, зэвсэглэж байсан саяхны түүх бий. Өнгөрсөн ням гарагт Энэтхэгийн аюулаас хамгаалах хүчин хил нэвтэрч ирсэн хоёр зэвсэгт бүлэгтэй тулгарч, нэг хүнээ алдсан боловч долоон босогчийг устгасан юм.

Ноён Бухари цааш нь “Энэтхэгийн Засгийн газар үгүйсгэх бодлогоо үргэлжлүүлж байна. Аяндаа үүссэн хувьсгал гэдгийг үгүйсгэлээ. Хэн ч

бие биенээ сонсохгүй байна. Кашмирийн залуусын тархинд энэ бол эцсийн тулаан гэсэн бодол суусан байгаа. Одоо эсвэл хэзээ ч үгүй” хэмээн өгүүлэв. Эсэргүүцлийг намжаахын тулд эрх баригчид сүүлийн хоёр сар үргэлжилсэн хөл хориог сунгажээ. 60 хоногийн хугацаанд ард иргэд үнэн хэрэгтээ цоожтой байж, сургууль, бизнес, нийтийн тээвэр бараг зогссон юм. Хөл хориог эсэргүүцсэн хүмүүсийг үрлэн сумаар буудсан нь ойрын зайд үхэл тарьж, нүдэнд хүнд гэмтэл учруулж байлаа.

Дотоод хэргийн сайд Ражнат Сингх аюулаас хамгаалах хүчинд хандан бослого өдөөгчдийг нухчин дарахыг уриалаад долоо хоногт багтаан сургууль, коллежуудыг нээхийг даалгажээ. Human Rights Watch байгууллагын Өмнөд Азийг хариуцсан захирал Минакши Гангули энэ тухайд Шинэ Дели хүний эрхийн зөрчил, шүүхийн шударга байдал зэргийг оруулаад Кашмир дахь тэрслүү үзлийн дотоод шалтгааныг судлах ёстой гэсэн байна.

2010 оны мөргөлдөөнийг намжаахын тулд Кашмирийн санаа бодлыг сонсдог баг томилон, салан тусгаарлах үзлийг сааруулах нарийвчилсан төлөвлөгөө гаргасан аж. Гэвч уг төлөвлөгөөг хэрэгжүүлж чадаагүй юм. Ноён Гангули “Тодорхой хугацаанд гомдол, зөрчил хуримтлагдсан. Засгийн газар Кашмирийнхан хүчирхийллээ зогсоо, тэгвэл яриа хэлэлцэх хийнэ гэсээр цаг алдлаа. Гэвч хүчирхийлэл зогсонгуут албаныхан Кашмирийг мартдаг. Тус мужийн асуудлыг шийдэх болно гэдгээ өөрсөө ард иргэдэд итгүүлэх ёстой” хэмээн өгүүлсэн билээ.



Үр тарианд татаас олгосон хэмээн Бээжинг буруутгалаа

Шон Доннан

АНУ Хятадыг цагаан будаа, эрдэнэ шиш, үр тарианы аж ахуйнуудаа хууль бусаар татаас олголоо хэмээн буруутгасан. Ингэснээр хэт үйлдвэрлэл, зах зээлийн гажуудлын талаарх шүүмжлэл дээр нь нэмэгдэв. Мягмар гарагт Дэлхийн худалдааны байгууллага уг асуудлыг хэлэлцэж эхэлсэн. Энэ нь Номхон далайн чөлөөт худалдааны гэрээг ирэх арванхоёрдугаар сард Конгрессоор батлуулж, бүс нутагт Бээжингийн өсөн нэмэгдэж буй нөлөөг хязгаарлах Обамагийн засаг захиргааны хүчин чармайлттай давхцлаа. Түүнчлэн Америкийн Ерөнхийлөгчийн сонгуульд өмнөх сурталчилгаанд дэлхийн худалдаа, Хятадын хэт үйлдвэрлэл, түүний нөлөө зэрэг асуудал



BMM©

гол байр суурь эзэлж байгаа юм.

Вашингтон саяхан гангийн импортдоо демпингийн эсрэг татвар нэвтрүүлснээр Хятадад дамжсан хэрэгтэй тэгш бус байдал өргөжихийн сацуу даяарчлалын муу нөлөөнөөс болсон мэтээр ярьж, тайлбарлаж байв. Мягмар гарагт нийтлэгдсэн тайлангийн нааштай тоо баримт ноён Трампын сурталчилгаа явагдсан хугацааг хамарч байгаа хийгээд маргааны сэдвийг шинэ өнцгөөс харах боломж олголоо.

2007-2009 оны санхүүгийн

орон гэж хандах Бээжингийн шаардлагыг эсэргүүцэж байгаа хэрэг. Энэ асуулга нь Обамагийн засаглалын хугацаанд Хятадын эсрэг үүсгэсэн 14 дэх зарга юм. Харин АНУ-ын хүчирхэг үр тарианы салбарын нэрийн өмнөөс тавьж буй анхны шаардлага

боллоо.

Ерөнхийлөгч Обама “Америкийн ажилчид, бизнесүүд болон фермерүүд дэлхийн зах зээлд шударгаар өрсөлдөж, ялж байгаа. Гэвч бусад орон дүрэм, журмыг хөсөрдүүлж, Америкийн ажилчид, фермерүүдийн хөдөлмөрийг үрэн таран хийж байгаа тохиолдолд бид тэдэнд хариуцлага хүлээлгэх болно” хэмээн мэдэгдсэн. Тэрбээр Хятад улс Азид өөрийн худалдааны бодлогыг идэвхжүүлж байгаа үед энэ арга хэмжээ хангалтгүй гээд оны эхээр Япон ба Азийн 10 улстай байгуулсан Номхон далайн түншлэлийн гэрээг (TPP) батлахын чухлыг онцлов.

Ноён Обама мягмар гарагт хэлсэн үгэндээ “Дэлхийн эдийн засаг хөгжихийн хэрээр бусад улс орнууд дагаж мөрдөхүйц

дээд стандартыг тогтооход АНУ тэргүүлэх үүрэгтэй оролцох нөхцөлийг бид хангах ёстой. Энэ бол Номхон далайн түншлэлийн зорилго юм” гэжээ. Обамагийн урагшуулахыг хичээж буй энэ гэрээг Конгрессоор батлуулахад ахуйн хүчирхэг лобби дэмжлэгээр арваннэгдүгээр сарын 7-ны сонгуулийн дараа гэрээг батлуулж амжина гэж найдаж байна.

TPP-г Конгрессоор батлуулахад газар тариалан зонхилдог муж улсын төлөөлөгчид гол үүрэгтэй агаад зарим нь ДХБ-д эхлүүлсэн

заргыг дэмжсэн байна. Уг хэргийн гол зүйл нь Бээжин ургац хураалтын үед цагаан будаа, эрдэнэ шиш, үр тарианы үнийг доогуур тогтоохын тулд фермерүүдэд 100 орчим тэрбум ам.долларын хөнгөлөлт үзүүлж байна гэсэн шүүмжлэл юм. Үнэн хэрэгтээ энэ бол татаас учир Хятад улс 2001 онд ДХБ-д элсэхдээ хүлээсэн үүргээ зөрчсөн явдал гэж үзэж байна.

Цаашлаад энэ нь хэт үйлдвэрлэлийн үр дагавар агаад Америкийн фермерүүд Хятадын болон дэлхийн зах зээлд өрсөлдөхөд сөрөг нөлөө үзүүлнэ. АНУ дэлхийд хамгийн том хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортологч бөгөөд өнгөрсөн онд 20 тэрбум ам.долларын бүтээгдэхүүнээ Хятадад худалджээ.



АНУ-д ядуурал буурч, орлого өссөн дүн гарав

Сэм Флеминг

АНУ-д хөдөлмөрийн зах зээл сайжирч, цалин хөлс дээшилсэн нь өсөлтийг дэмжиж байна. Өнгөрсөн онд өрхийн дундаж орлого нэмэгдсэн тухай мэдээ Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгчдийн бараан дүрслэлээс эрс ялгаатай байгаа юм. Тус улсад өрхийн бодит дундаж орлого 2007 оноос хойш хамгийн өндөр дүнтэй гарч, 2014-2015 оны дунд үеэс 5.2 хувь дээшилснээр 56516 ам.долларт хүрснийг Хүн амын бүртгэлийн товчооноос мэдээлсэн байна.

Саяхан АНУ-д өрнөсөн улс

төрийн маргаан хэлэлцүүлэгт орлого урт хугацаанд өсөөгүй хэмээн дүгнэж байсан. Энэ нь Дональд Трампын сурталчилгаанд нэмэр болж, Америкийн дундаж давхарга ашигхын хэрээр тэгш бус байдал өргөжихийн сацуу даяарчлалын муу нөлөөнөөс болсон мэтээр ярьж, тайлбарлаж байв. Мягмар гарагт нийтлэгдсэн тайлангийн нааштай тоо баримт ноён Трампын сурталчилгаа явагдсан хугацааг хамарч байгаа хийгээд маргааны сэдвийг шинэ өнцгөөс харах боломж олголоо.

2007-2009 оны санхүүгийн

уналтын дараах хугацаанд гаргасан Обамагийн засаг захиргааны үзүүлэлтийг хамгаалахыг Ардчилсан намынхан бүх хүчээрээ оролдож буй цаг үе. Ерөнхийлөгч болон АН-аас нэр дэвшигч Хиллари Клинтон нарын хувьд эдийн засаг сэргэж буй ч орлого өсөхгүй байгаа асуудал сөрөг нөлөө үзүүлсэн юм. Хүн амын бүртгэлийн товчооны тоог харахад 2010 оноос хойш үргэлжилсэн хөдөлмөрийн зах зээлийн өсөлт 15.1 сая ажлын байр бий болгож, эцсийн эцэст өрхийн орлогод өгөөжөө хүртээж байгаа

боллоотой.

Гэвч 2015 онд гарсан 1.6 хувийн өсөлт нь хямралын өмнөх түвшинд ч хүрэхгүй, 1999 оны дээд үзүүлэлтээс 2.4 хувь доогуур байгаа юм. Орлогын өсөлт хүн амын дээд давхарга бус доод болон дундаж орлоготой хэсэгт илүү туссан нь орлогын тэгш бус байдал буурч буйг харуулав. Мичиганы их сургуулийн эдийн засгийн профессор Жастин Волферс дундаж орлогын түвшин сэтгэл түгшээсн асуудал хэвээр байгаа. Гэхдээ дундаж давхаргын хувьд ахиц гарсан нь ажиглагдлаа

гэжээ. Тэрбээр “Гарсан ахицын хамгийн чухал шинж чанар нь тогтмол байгаа явдал. Эхний хоёр гурван жилдээ тийм түргэн өсөөгүй ч долоон жилийн хойно үргэлжилсээр байна” хэмээн онцлов.

American Action Forum байгууллагын тэргүүн Дуглас Холц-Еакин ДНБ-ий хоёр хувийн өсөлт урт хугацаанд олон жилийн өмнөх шиг орлогын тогтвортой өсөлт авчрахгүй байх гэж болгоомжилж буйгаа илэрхийллээ. Өсөлтийн түвшин испани хэлт хүн амын дунд хамгийн өндөр буюу 6.1, цагаан

арьст иргэдийн хувьд 5.6, харин африк гаралт америкчуудын дунд хамгийн бага буюу 4.1 хувьтай байна. Бүтэн цагаар ажилладаг эмэгтэйчүүдийн орлогын өсөлтийг бүтэн ажилтай эрчүүдтэй харьцуулахад 80 хувь өссөн хэмээн бүртгэгдсэн нь статистикийн хамгийн дээд үзүүлэлт болжээ. Эдгээр нааштай дүнгээс гадна жилийн туршид ядуусын тоо 3.5 саяар буурсан. Энэ нь ядуурлын түвшинг 13.5 хувиар доошлуулсан тооцоо гарсан байна.



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Тамирчдын мэдээллийн хулгайд оросууд буруутай юу



BVM©

Мэдээлэл нь задарсан тамирчид дотор Риогийн олимпоос дөрвөн алтан медаль хүртсэн гимнастикч Симона Байлз оржээ.

Мэдээлэл нь задарсан тамирчид дотор Риогийн олимпоос дөрвөн алтан медаль хүртсэн гимнастикч Симона Байлз, теннисийн од Винус болон Серена Уильямс, сагсан бөмбөгийн од Илена Делле Донн багтжээ. Өгөгдлийн санд нь хууль бусаар халдсаныг WADA ч баталж байгаа. Халдлага ОХУ-аас эхтэйг уг хэргийг мөрдөж буй хууль сахиулах байгууллага тайлбарласан. “Энэхүү гэмт үйлдэл сэргээштэй тэмцэх

олон улсын байгууллагаас ОХУ-д итгэх итгэлийг сэргээх найдварыг хөсөрдүүллээ” хэмээн WADA-гийн ерөнхий захирал Оливье Ниггли мэдэгдэв. ОХУ-ын тагнуулын алба дээрх халдлагад “Огт хамаагүй” талаар Кремль яаравчлан тайлбар хийсэн юм. “Москва болон ОХУ-ын тусгай албад хэрэгт оролцсон талаарх аливаа сэжгийг миний бие эрс үгүйсгэж байна” хэмээн Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч Дмитрий

Песков мэдэгдлээ. АНУ-ын Ардчилсан намын үндэсний хорооны өгөгдлийн санд энэ сарын эхээр нэвтэрсэн хэрэгт оросуудыг сэжиглэсэнтэй холбогдуулан Ерөнхийлөгч Владимир Путин тайлбар өгч байсан удаатай. Ноён Песков ч хакерууд халдлагаа оросууд үйлдсэн мэт харагдахаар зохион байгуулсан байх үндэслэлтэй хэмээн өгүүлэв. Сэргээш хэрэглэснийг батлах төстийн дүнг эрх баригчид зохион байгуулалттай нуун

дарагдуулсан нь илэрсэн. Иймд Риогийн олимпод ОХУ-ын тамирчдыг үл оролцуулах шийдвэрийг WADA гаргаж байлаа. Уг арга хэмжээг ОХУ-ын нэр хүндийг гутаах зорилготой өрнөдийнхний хуйвалдаан хэмээн үзсэн Кремль хилэнт мэдэгдэл гаргасан. Тус улсын баг тамирчдад бүрэн хориг тавихаар төлөвлөж байсан Олон улсын олимпын хороо хожим нь нэр бүхий тамирчдыг олимпод үл оролцуулахаар шийдвэрлэсэн билээ. Риогийн паралимпэд ч

ОХУ-ын тамирчдад бүрэн хориг тавиад байгаа юм. Fancy Bears бүлэг вэбсайтдаа байршуулсан мэдэгдэлдээ хэд хэдэн улсын шигшээ багтай холбоотой баримт материал дэлгэхээр сүрдүүлжээ. Орос хэлтнүүдийн дунд түгээмэл англи хэлний дүрмийн алдаа ихтэй уг мэдэгдэлд “Луйврын аргаар ялж нэр хүндээ шившиглэсэн АНУ-ын багаас ажлаа эхэллээ” хэмээн бичсэн байна. Хакеруудын гарт орсон баримт материалд Риогийн

олимпын үеэр сэргээш хэрэглэсэн тамирчдын тухай өгөгдөл орж байгаа, эсэх нь тодорхойгүй. Хулгайд алдсан материал дотор Риогийн үеэр авсан сэргээшийн тест байгааг WADA ч мэдэгдсэн. Тестийн материалд эрх бүхий спортын байгууллагуудаас хүлээн зөвшөөрсөн “Эмчилгээний зориулалттай” эм хэрэгслийн тухай өгөгдөл багтжээ. “Бид ямар нэгэн хувийн байгууллагаас гаргасан тайлбарт хариу өгөх албагүй. Гэхдээ АНУ-ын баг сэргээшийн эсрэг байгууллагаас гаргасан эмчилгээ, эм зүйн бүхий шаардлагыг Риогийн олимпын үеэр 100 хувь даган мөрдсөн нь маргашгүй үнэн” хэмээн АНУ-ын Олимпын хороо мэдэгдэв. АНУ-ын гимнастик, теннис, сагсан бөмбөгийн удирдах байгууллага одоогоор хариу тайлбар өгөөгүй. Харин Олон улсын теннисийн холбоо, Олон улсын гимнастикчдын холбоо дүрэм зөрчиж нуун дарагдуулсан хэрэг илрээгүй хэмээн тайлбарласан. Риогийн олимпын үеэр ОХУ-ын гүйлтийн тамирчин Юлия Степановагийн цахим дансанд хууль бусаар нэвтэрсэн хэрэг гарсан талаар WADA урьд нь мэдэгдсэн аж. ОХУ-ын төрийн мэдлийн мэдээллийн хэрэгслүүд WADA-гийн өгөгдлийн санд халдсан хэрэгт баярлаж байгаагаар нууж чадахгүй байна. Олимпын нээлтийн ёслолд WADA-гийн удирдлага шээсний сорьц, ууттай мөнгө барьсаар алхаж буй хүүхэддэйн кино дүрсийг “РИА Новости” телевизээр үзүүлээ. FT

Шинэ Ерөнхийлөгч, хуучин арга барил



BVM©

Жэк Фарчи Узбекистан ахархан түүхэндээ анх удаа шинэ Ерөнхийлөгчтэй боллоо. Тус улсыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд байх үеэс удирдаж асан хүчирхэг бие хүн Ислам Каримов нас эцэслэсэн тул ноён Шавкат Мирзиёев өнгөрсөн долоо хоногос Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж эхлэв. Шавкат Мирзиёев гэж хэн бэ? Шавкат Миромонович Мирзиёев 2003 оноос Узбекистаны Ерөнхий сайдын албыг хашиж иржээ. Урьд нь тэрбээр төв Узбекистаны Жиззах мужийн тэргүүнээр ажиллаж байгаад Самаркандын захирагчаар тушаал дэвшсэн түүхтэй. Мирзиёев чухам ямар хүн бэ? Хувь хүний хувьд тэрбээр Каримовтай адил эрс хатуу, эзэрхэг авиртай нэгэн хэмээн ажиглагчид дүгнэж байна. “Яг Каримов шиг дарангуйлагч. Илүү чанга ч байх. Лав оюуны хувьд Каримовыг гүйцэхгүй” хэмээн мэдээллийн “Фергана” чөлөөт агентлагийн редактор Данил Кислов тайлбарлав. Бүс нутгийн захирагчаар ерөнхий сайд болсон ноён

Мирзиёев нь Узбекистаны хөвөнгийн тариаланг давхар хариуцдаг. Жил бүр тус улсын сая сая иргэдийг ургац хураалтад дайчилдаг уламжлалыг хүний эрхийн байгууллагууд албадлагын хөдөлмөр хэмээн шүүмжилсээр ирлээ. Ноён Мирзиёев олны нүдэнд өртөх дургүй нэгэн. Тэрбээр Каримовын атааг төрүүлэхгүйн тулд өөрийг нь телевизээр харуулахыг хориглосон заавар төрийн мэдээллийн хэрэгслүүдэд өгч байжээ. Үүнийг 2008 онд WikiLeaks-д тавигдсан АНУ-ын дипломат албаны материал баталдаг. Байнгын Ерөнхийлөгч хэн болж таарах вэ? Ноён Мирзиёев болов уу. Узбекистанд арванхоёрдугаар сарын 4-нд Ерөнхийлөгчийн сонгууль болох ёстой. Гэвч чөлөөт, ардчилсан, шударга сонгууль хэзээ ч болж байгаагүй хэмээн олон улсын ажиглагчид тайлбарладаг тус улсад өөр шинэ хүн гарах талаар горьдолтгүй. Тэрбээр албан ёсоор нэрээ дэвшүүлээгүй. Гэхдээ Узбекистаны засгийн эрхийг атгагчид Каримовын залгамжлагчаар ердөө ганц хүнийг зааж байгаа нь ноён Мирзиёев. Түүнийг

Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгчээр томилсон нь Узбекистаны үндсэн хуультай зөрчилдөж байгаа. Каримовыг оршуулах ёслолыг энэ хүн л удирдсан. Өнгөрсөн долоо хоногт ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путинтэй энэ хүн л улсаа төлөөлөн уулзсан. Узбекистанд цаашид байдал өөрчлөгдөх үү? Ойрын мөддөө лав өөрчлөгдөхгүй. Ноён Мирзиёев өнгөрсөн долоо хоногт хэлсэн үгэндээ Каримовын бодлогыг залгамжлахаар амласан. Тэрбээр “Төрийн тэргүүний улс төрийн өвийг залгамжлан үлдэх нь та бидний ариун үүрэг” хэмээн мэдэгдлээ. Мөн улс орны хуртөвтөр байдлыг хангах үүднээс аюулгүйн арга хэмжээг чангатгахыг уриалав. Юутай ч тус улсын иргэд Каримовын дарангуй дэглэм сулрах нь хэмээн найдаж байсан нь талаар болох төлөвтэй. “Удирдлагын арга барилын хувьд Мирзиёев төмөр нударгат Каримовын хуулбар” хэмээн 2004 онд хаагдсан Ташкентын Жорж Соросын нээлттэй нийгэм хурээлэнгийн захирал Алишер Илхамов үзэж байна. Узбекистаны эдийн засаг

Ямар байна вэ? Олон улсын валютын сангийн судалгаагаар энэ онд Узбекистаны эдийн засгийн өсөлт таван хувь болтлоо буурна. Энэ нь сүүлийн арав гаруй жилд тохиолдоогүй уналт. Сая сая узбекчууд ажил хайн зорьдог ОХУ-д байдал хүнд байгаа нь Дундад Азийн энэ улсад бэрхшээл учруулна. Ноён Мирзиёев хэлсэн үгэндээ эдийн засгийг хөгжүүлэхэд анхаарах таван чиг шугам дохон дурдсан. Үүнд, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, металл, хүнсний үйлдвэрлэлийг өргөжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, жижиг бизнесийг дэмжих замаар энэ онд нэг сая ажлын байр бий болгох, дэд бүтэцэд хөрөнгө оруулах. Тэрбээр “Дэлхий даяар эдийн засаг удааширч, амин чухал экспортын бүтээгдэхүүний үнэ унаж буй нөхцөлд бид шинэчлэл өрнүүлэхэд анхаарах ёстой” хэмээн тайлбарлав. Гадаад харилцааны хэтийн төлөв? Ташкентаас Москватай тогтоосон гадаад харилцаанд лавтай өөрчлөлт орно хэмээн шинжээчид үздэг. Юутай ч тэрбээр уламжилж ирсэн зожирхох бодлогыг хэвээр үргэлжлүүлэхээ амласан. “Цэрэг, улс төрийн эвсэл холбоонд үл нэгдэх, гадаадын цэргийн баазыг нутаг дэвсгэртээ үл байршуулах Узбекистаны уламжлалт бодлого гуйвшгүй” хэмээн тэрбээр мэдэгдсэн юм. FT

Өндгөн эсгүйгээр амьдрал үүсгэнэ

Клайв Куксон Эрдэмтэд өндгөн эс өсгөхгүйгээр эрүүл чийрэг үр хөврөл үүсгэж чадсан нь хоёр зуун жил тогтнож ирсэн уламжлалт ойлголтыг нураав. Их Британийн Батын их сургуулийн (Bath university) биологичид партеногенот гэгддэг амьдрах чадваргүй үр хөврөлд эр бэлгийн эс суулгаж замаар хулгана үржүүлж чадлаа. Өндгөн эснээс эрс ялгаатай хуваагддаг энэхүү арга нь бие махбодийн бусад эсийн үйл ажиллагаатай төстэй байгаа юм. Шинэ арга нь зарчмын хувьд эр бэлгийн эс ашиглан арьс юм уу, биений бусад эд эрхтнээс авсан эсийг үржүүлэх боломж бүрдүүлж байгааг тус судалгааг удирдсан Тони Перри тайлбарлаж байна. Тэр ч байтугай эмэгтэй хүний оролцоогүйгээр хоёр эр хүний дундаас хүүхэд “төрүүлэх” боломжтой. “Бидний ажил эмбриологич буюу үр хөврөл судлаачдын дунд тэртээх XIX зуунаас тогтсон домгыг эвдэж болзошгүй. Урьд нь сүүн тэжээлтний хувьд өндгөн эс байж л эр бэлгийн эс үржилд орж өсдөг гэсэн ойлголт бат тогтсон байлаа” хэмээн ноён Перри тайлбарлав. “Энэхүү ер бус судалгаа нь хүмүүний амьдралын үүсэл, үр хөврөл өсөж бойжих үе шат буюу үржил явагддаг

механизмыг ойлгоход тус болох нь дамжиггүй” гэж уг судалгааг санхүүжүүлсэн Их Британийн Анагаах ухааны судалгааны зөвлөлийн хөгжлийн биологийн хөтөлбөрийн менежер Пол Колвил-Нэш үнэлж байна. Тэрбээр “Хаа байсан ч гэлээ та бид үргүүдийг эмчлэх өдөр нэг цагт ирж л таарна” хэмээн нэмж өгүүлээ. Nature Communications сэтгүүлд нийтлэгдсэн уг судалгаа нь хулганын өсөж амжаагүй өндгөн эсийг химийн аргаар партеногенот болгон хувиргах туршилтаас гараагаа эхэлсэн түүхтэй. Судалгааны багийн хоёр гишүүн, Японы эмбриологич Торү Сүзүки, Маки Асами нар үүсгэсэн партеногенот дотор эр бэлгийн эс суулгажээ. Эрдэмтэд хүний үргүүдэд эмчлэхэд өргөн хэрэглэдэг технологи болох өндгөн эсэнд эр бэлгийн эс суулгадаг ICSI арга ашиглан туршилт хийсэн юм. Туршилтын явцад партеногенот нь “эцэг” болох донор эр бэлгийн эс, “эх” болох донор эмбрионы хоёулангийнх нь генийг хадгалсан хэвийн хөгжилтэй үр хөврөл болон бойжив. Уг аргаар үүсгэсэн хос хулгана эрүүл чийрэг өссөн төдийгүй үр удмаа үлдээсэн байна. Зарчмын хувьд эр бэлгийн эс болон өндгөн эс оролцуулахгүйгээр хоёр өөр бие махбодийн эсийг “эвцэлдүүлэх” нь ч боломжтой байж мэдэх талаар ноён Перри өгүүлж байна. “Чадах, эсэхийг хэлж мэдэхгүй нь. Гэхдээ алсын ирээдүйд боломжтой болчих аваас хүмүүс чухам өнөөдрийг л гарааны цэг хэмээн дурсах болно” гэжээ. FT



Эдийн засаг

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Ипотекоос хамааралтай салбарын ирээдүй

Хуучин орон сууцны үнэ 11.9 хувиар буурчээ

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Орон сууцны зах зээл өсөлттэй гарахад ипотекийн зээл гол найдвар болсон хэвээр байна. Найман хувийн хүүтэй орон сууцны зээлийг энэ сард түр хугацаагаар зогсоосон. Гэхдээ барилгын салбарын борлуулалтын “хувь заяа”-г уг зээл шийдэх нь тодорхой. Монголбанк болон арилжааны банкуудын удирдлагын түвшинд шийдэлд хүрснээр зээлийн бүтээгдэхүүн цааш “хөдлөх”-өөр байгаа. Тэр болтол ипотекийн зээлийн санхүүжилтийг үргэлжлэн олгохгүй гэдгээ төвбанкнаас зарласан.

Ипотекийн зээл царцсан нь орон сууцны борлуулалтад төдийгүй барилгын салбарт ч сөргөөр нөлөөлөхөөр байгааг тус салбарынхан учирлаж байна. Тэд ипотекийн зээлийг хэвийн үргэлжлүүлэх боломж, бололцоог бүрдүүлж өгөхийг Засгийн газрын тэргүүнээс хүссэн. Орон сууцны нийлүүлэлт өнгөрсөн хугацаанд тасралтгүй нэмэгдсэн ч иргэдийн худалдан авах чадвар муудаж, банкууд орон сууцны зээлээ хязгаарлаж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор орон сууцны борлуулалт өнгөрсөн онтой харьцуулахад энэ онд огцом буурах төлөвтэй байна.

Хэдийгээр нийлүүлэлт харьцангуй өсөлттэй байсан ч цаашид агших эрсдэл хэвээр. Орон сууцны зах зээл дэх эрэлтийг тодорхойлох нэг гол үзүүлэлт нь тухайн сард арилжааны банкуудын шинээр олгож байгаа зээлийн хэмжээ, зээлдэгчийн тоо байдаг. Тэгвэл энэ үзүүлэлт он гарсаар тасралтгүй буурч ирсэн нь зах зээлийн төлөвийг бүлгэрүүлсээр.

Нийлүүлэлт өндөр, эрэлт бага байгаа тохиолдолд үнэ буурдаг. Эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан эрэлт буурснаар гэрлийн хурдаар өсөж байсан орон сууцны үнийн уналт жил

Ипотекийн зээлийг хэвийн үргэлжлүүлэх боломж, бололцоог бүрдүүлж өгөхийг Засгийн газрын тэргүүнээс барилгачид хүслээ.

дамнан үргэлжилж байна. Үнийн хөөсрөлт татарч, барилгын салбар өдгөө санхүүгийн хүндрэлтэй золгоод байгаа. Орон сууцны үнийн өсөлт саарсан нь сайн мэдээ. Гэхдээ эрэлт огцом буурсан нь төлбөрийн чадвартай иргэдийн тоо багассаныг нэг талаар илтгэх буюу. Эрэлтийг нэмэгдүүлдэг гол хүчин зүйл нь ипотекийн зээл байв.

Та шинэ болон хуучин орон сууц худалдан авахаар сонирхож байгаа бол түр хүлээгээрэй. Төгрөгийн ханшийн уналтыг эс тооцвол орон сууцны үнэ цаашид хямдарсан хэвээр байх юм. Эрэлтгүй зах зээлд үнийн уналт ирэх онд ч үргэлжлэхээр байгааг үл хөдлөх хөрөнгийн

зах зээлийн зарим судалгаанд дурдсан байна. Үүнд, “Тэнхлэг зууч” компанийн сар тутам гаргадаг орон сууцны үнийн индексийг дурдаж болно. Орон сууцны үнийн индекс наймдугаар сард 1.5 хувьтай гарсан. Тэгвэл энэ сард ипотекийн зээл түр зогсонтой холбоотойгоор үнэ буурах магадлал нэмэгджээ.

Барилгын компаниудыг мөнгөний урсгалтай залгуулж ирсэн ипотекийн зээл царцсан нь иргэдээс захиалга авч эхэлсэн орон сууцны зарим төсөл зогсоход хүргээд байгаа юм. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат барилгын салбарынхантай уулзах үеэрээ “Эхний ээлжинд

зогссон барилгуудын асуудлыг судалж, шийдвэрлэнэ” хэмээн амалсан. Зогссон барилгуудыг хөдөлгөх гарц нь борлуулалтыг дэмжихээс эхэлж таарна. Нийслэлд 50 хувиас дээш гүйцэтгэлтэй 25 мянган орон сууц бий. Үүнийг бүрэн ашиглалтад оруулахын тулд барилгын компаниудын борлуулахад хэдийнэ бэлэн болсон 8000 орон сууцыг эзэнтэй болгож дууссаны дараа л дээрх 25 мянган орон сууцны “ирээдүй” тодорхой болох дүр зураг ажиглагдаж байна.

Орон сууцны үнэ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9.2 хувиар буураад байна. Шинэ орон сууцны үнэ оны

эхэн үеэс 4.2, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 7.1 хувиар хямдарсан. Хуучин орон сууцны үнэ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11.9 хувиар буурсан дүнтэй гарсан. Ашиглалтад бүрэн орсон найман мянган орон сууцыг ипотекийн зээлээр дамжуулан эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтойг зарим эдийн засагч хэлж байна. Барилгын салбарын өндөр өсөлт ард үлдэж, хүндрэлийн үе тохиож байгаа нь энэ.

» Шинэ орон сууцны үнэ оны эхэн үеэс 4.2, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 7.1 хувиар хямдарсан.

» Нийслэлд 50 хувиас дээш гүйцэтгэлтэй 25 мянган орон сууц байна.

» Үнийн хөөсрөлт татарч, барилгын салбар өдгөө санхүүгийн хүндрэлтэй золголоо.

Нийлүүлэлт илүүдэлтэй байгаа учраас байрны үнийг боломжит хэмжээнд бууруулж, мөнгөө чөлөөлөн, эргэлтэд оруулах нь хамгийн чухал шийдвэр болжээ. Байр худалдан авах боломжтой, зээлийн нөхцөл, шаардлагыг хангасан 8.7 мянган өрх байгаа аж. Нийлүүлэлтийн илүүдэл, хуучин орон сууцны үнийн бууралтыг дагаад шинэ орон сууцны үнэ цаашид ч буурах хандлага ажиглагдсан хэвээр. Орон сууцны үнэ богино болон дунд хугацаанд өсөх боломж ч хомс байна. Байртай болох хүсэлтэй иргэдийн 83 хувь нь ипотекийн зээлд хамрагдах хүсэлтэй байгаа юм. Энэ тохиолдолд түр зогссон ипотекийн зээл урагшлах, эсэхээс орон сууцны зах зээл хамаарах нь. [ZGM]

ФОРУМ

140 сая ам.долларын бүтээгдэхүүн экспортолжээ

Б.Цацралт
Шинжээч

Монгол Улсаас БНЧУ руу 2016 оны эхний хагас жилийн байдлаар 140 сая ам.долларын бүтээгдэхүүн экспортолсон байна. Харин импортын дүн тайлант хугацаанд 44 сая ам.доллар байсан талаар МҮХАҮТ-ын дарга М.Оюунчимэг Монгол, Чехийн бизнес форумын үеэр мэдээллээ. Энэхүү бизнес форумд БНЧУ-аас 20

гаруй, Монголын талаас 70 бизнес эрхлэгч оролцож, хамтран ажиллах боломжийн талаар ярилцлаа.

Монгол Улсын хувьд Чех рүү гол төлөв ноос, ноолуур, сүлжмэл хувцас зэрэг бараа бүтээгдэхүүн экспортолдог. Цаашид газар тариалан, мал аж ахуйн салбар болон аж үйлдвэрийн цогцолборыг байгуулахад Чехийн талаас байгальд ээлтэй тоног төхөөрөмж, ноу хауг нэвтрүүлэх шаардлагатай байгааг МҮХАҮТ онцолсон.

Өнгөрсөн хугацаанд Чехийн Засгийн газрын тусламжийн хүрээнд Монголд 50 гаруй сая еврогийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.

Чехийн бизнес эрхлэгчдийн хувьд Монгол Улсад хэрэгжих томоохон төслүүдэд оролцох сонирхолтой байгаагаа илэрхийлэв. Энэхүү бизнес форумын үеэр хоёр улсын Худалдааны танхим хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. [ZGM]

БОНД

Засгийн газрын бондын арилжаа сэргэлээ

О.Одгэрэл
Шинжээч

Өнгөрсөн тавдугаар сараас хойш зогсоод байсан Засгийн газрын бондын арилжаа дахин эхэллээ.

Энэ удаад Сангийн яамнаас Монголбанкнаар дамжуулан 155 тэрбум төгрөгийг дотоодын зах зээлээ төсөвт татан төвлөрүүлэх юм байна. Хамгийн богино хугацаатай буюу харьцангуй эрэлт өндөр байдаг 12 долоо

хоногийн хугацаатай Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ыг энэ удаа 50 тэрбум төгрөгөөр арилжааллаа. Мөн 100 тэрбум төгрөгийн 28 долоо хоногийн хугацаатай, таван тэрбум төгрөгийн 52 долоо хоногийн хугацаатай ЗГҮЦ-ыг дотоодын хөрөнгө оруулагчдад санал болгожээ.

Монголбанк энэ оны наймдугаар сарын 18-нд мөнгөний бодлогын хүүг 10.5-д 15 хувьд хүргэж, 4.5 нэгж хувиар нэмэгдүүлсэн юм. Бодлогын үр

дүнтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор төгрөгийн илүүдэл нөөцийг татах дараах шат дараалсан арга хэмжээг Монголбанкнаас авсан байна. Үүнд, харьцангуй урт хугацаатай 12 долоо хоногтой Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ыг банк хоорондын захад арилжаалж эхэлжээ.

Энэ нь төгрөгийн илүүдэл нөөцийг татах, төгрөгөөс ам.доллар руу шилжсэнтэй холбоотой, огцом нийлүүлэлт үүсэх эрсдэлийг бууруулах зорилготой аж.. [ZGM]

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Самнасан ноолуурын экспорт 14.7 хувиар буурав

Т.Элиса
Шинжээч

Монгол Улс энэ оны эхний найман сард 20.4 сая ам.долларын самнасан ноолуур экспортолсон нь өмнөх оны мөн үеэс 14.7 хувиар буурсан талаар Үндэсний статистикийн хорооноос мэдээллээ. Үүнээс хамгийн их буюу 15.4 сая ам.долларын үнэ бүхий ноолуурыг Итали улсад экспортолжээ. Энэ нь нийт экспортын 76 хувийг бүрдүүлж байна. Харин 10.7 хувь буюу 2.2 сая ам.долларын ноолуурыг Их Британид, 8.1 хувь буюу 1.6 сая ам.долларын самнасан ноолуурыг БНХАУ-д экспортолсон байна.

Монгол Улсын хувьд боловсруулсан ноолуурын гол зах зээл нь Итали, Их Британи зэрэг Европын орнууд бөгөөд “Ханбогд кашмер”, “Говь” зэрэг компани бүтээгдэхүүнээ экспортод гаргадаг аж. Харин Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монголоос Японд экспортлох ноолуур, ноолууран бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн байна. 2016 оны эхний найман сард нийт 293.1 мянган



ам.долларын самнасан ноолуур Японд экспортолсон нь жилийн өмнөхтэй харьцуулахад 3.7 дахин өссөн үзүүлэлт болохыг Үндэсний статистикийн хорооны мэдээллээс харж болно.

Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд гаалийн тарифын хөнгөлөлт эдэлж бүтээгдэхүүнээ экспортод гаргах хүсэлтэй 20 гаруй компани МҮХАҮТ-аас 100 гаруй төрлийн гарал үүслийн гэрчилгээ аваад байгаа аж. Үүнээс ноолууран бүтээгдэхүүн голлох хувийг “Говь” компанийн хувьд Европоос гадна ОХУ-ын зах зээлд гаргах экспорт нь нэлээд жин дардаг. Самнасан ноолуурын экспорт биет дүнгээрээ 308.8 тоннд хүрсэн нь 2015 оны эхний найман сартай харьцуулахад 2.8 хувиар буурсан дүн юм. [ZGM]

ЗГМ ТОВЧХОН

» ТАЙЛАН

576.5

мянга
Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд энэ оны хоёрдугаар улиралд нийт 37.2 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 576.5 мянган ажилчин хамрагдсан байна.

» ЗЭЭЛ

0.3

хувь
Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл энэ оны эхний найман сарын байдлаар нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0.3 нэгжээр нэмэгджээ.

» ТӨСӨВ

23.6

хувь
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1808.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Алдагдал өсөхөд орлого 0.4 хувиар буурч, зарлага 23.6 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв.

» ВАЛЮТ

8.1

хувь
Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн сард 8.1 хувиар суларсан байна.

» МӨНГӨНИЙ БОДЛОГО

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит хурлаар “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хэлэлцлээ.

» ГАДААД ХУДАЛДАА

5.1

тэрбум
Монгол Улс дэлхийн 140 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 5.1 тэрбум ам.доллартай тэнцэж байна.

» ГАЗАР ТАРИАЛАН

10.9

мянга
Улсын хэмжээнд энэ оны есдүгээр сарын байдлаар 10.9 мянган тонн төмс, 11.9 мянган тонн хүнсний ногоо, 380.6 мянган тонн өвс хадлан, 2.7 мянган тонн гар тэжээл бэлтгэжээ.

» ТЭЭВЭР

9.3

хувь
Төмөр замын тээвэрээр тээсэн ачаа энэ оны наймдугаар сард 1719.8 мянган тонн болж, өмнөх сарынхаас 147 мянган тонн буюу 9.3 хувиар өссөн байна.

» САНХҮҮГИЙН ТОЛЬ

Зардлын инфляци (Cost-push inflation)
Үйлдвэрлэлийн өртөг зардлын өсөлтөөр өдөөгдсөн инфляци.

Урт позици (Long position)
Тухайн хөрөнгийн үнэ нь өснө гэсэн хүлээлтээр үнэт цаас, бараа, валют худалдан авах.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ, доллар	2240.74
Евро	2517.25
Япон, иен	21.7
ОХУ, рубль	34.46
БНХАУ юань	335.91
БНСУ вон	1.99

Сурталчилгаа



ZAISAN VILLA

Бидний сэтгэлийн үзүүр ТАНЫ ИТГЭЛИЙН УГТ

Загварын байр үзэх
бүртгэл хийгдэж байна



ЭХНИЙ ЭЭЛЖ 2016 ОНЫ 4-р улиралд ашиглалтанд орно

ЗАХИАЛГА АВАХ УТАС

96118811-96116611

www.zaisanvilla.mn

No 59/3-1, Ar Zaisan Street
11th Khoroo, Khan-uul District
Ulaanbaatar 8 Mongolia